

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-13

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 14-59

1. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” /Монголбанк 2023.12.26-ны өдөр ирүүлсэн/ 14-19

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлан 19-31

3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, нэн яаралтай/ 31-45

4. Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлан 45-53

5. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүй 53-59

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
04 дүгээр сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 29 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Ганибал;

Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн, Ч.Хүрэлбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг, Т.Доржханд, Д.Өнөрболор.

Нэг. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.12.26-ны өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн захирал П.Эрдэнэтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн бөгөөд дэд дарга Н.Хүдэрчулуун, мөн хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга Н.Оюунчимэг, мөн газрын референт Б.Лхагвасүрэн, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Долгорсүрэн, Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд, Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Энхтуяа, Компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга А.Авир, Банк бус санхүүгийн байгууллагын газрын ахлах зөвлөх Д.Болдмягмар, Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн бөгөөд дэд дарга Н.Хүдэрчулуун танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун, мөн хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг сонслоо.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, нэн яаралтай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монголбанкны Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал А.Батсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын мэргэжилтэн Б.Агиймаа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Ашигт малтмал газрын тосны газрын дарга Л.Баярмандал, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга Д.Батмагнай, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан тусгайлсан саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Д.Батлут нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн талаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “салбарын” гэсний дараа “, авто зам, төмөр замын дэд бүтцийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “шууд удирдлага” гэснийг “үйл ажиллагааны удирдлага” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2.1, 8.3.1 дэх заалтын “шууд удирдлагыг” гэснийг “үйл ажиллагааны удирдлагыг” гэж тохиолдол бүрд нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Хөгжлийн” гэсний өмнө “Үндэсний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “орон сууц зэрэг суурь хэрэгцээг хангах” гэснийг “орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төрийн сангийн нэгдсэн” гэснийг “Монголбанк дахь төрийн сангийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.2.б дэд заалтын “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд 15 дугаар заалт нэмэх:

“15.Засгийн газрын 2011 оны 98, 2012 оны 116, 2012 оны 201, 2015 оны 151, 2016 оны 334, 2017 оны 154 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын иргэдийн эзэмшиж байсан “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцаанаас хасагдсан, суутгагдсан хувьцааг тухайн иргэн хүсвэл 1072 хүртэлх нэгж хувьцааг 933 төгрөгөөр буцаан худалдан авах арга хэмжээг 2026 оны 12 сарын 31-нийг дуустал хэрэгжүүлнэ.” гэсэн саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу санал хураалт явуулах боломжгүй тухай мэдэгдэж, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Улсын Их хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг, мөн 12 дугаар зүйлийн 12.8, 12.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын, авто зам, төмөр замын дэд бүтцийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Т.Энхтүвшин нар үг хэлж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсгийн “ордын төрийн эзэмшлийн хувийг” гэснийг “ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “эзэмшлийн” гэснийг “төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

8.1.Сангийн эх үүсвэрийг холбогдох журмын дагуу хуваарилалт хийснээс хойш ажлын таван өдрийн дотор Монголбанкн дахь Сангийн дансанд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг, 8.3 дахь хэсгийн, 9¹ дүгээр зүйлийн 9^{1.1} дэх хэсгийн “энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Сангийн” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 5³ дугаар зүйлийн “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.2-г” гэснийг “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.6-д” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 53 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “33.2.11” гэснийг “33.2.10” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5

Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 33 дугаар зүйлийн 33.2.10 дахь заалтын “33.2.6-д” гэснийг “33.2.6, 33.2.10-д” гэж, мөн зүйлийн 33.2.10 дахь заалтын дугаарыг “33.2.11” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “5.3.27” гэснийг “5.3.26” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 21.1.16 дахь заалт, 30.14 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчит /өмчийн оролцоотой/” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 30.10.1 дэх заалтын “ашигт малтмалын” гэснийг “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын” гэж өөрчилж, мөн зүйлийн 30.10.2 дахь заалтын “бусад тохиолдолд” гэсний өмнө “энэ хуулийн 30.10.1-д зааснаас” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “сангийн” гэсний дараах, мөн зүйлийн “орлого,” гэсний дараах “хөрөнгө оруулалтын орлого” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийн “20-оос” гэснийг “34-өөс” гэж өөрчилж, мөн хэсгийн “эзэмших” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийн “20-оос” гэснийг “34-өөс” гэж өөрчилж, мөн хэсгийн “эзэмших” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5.8 дахь хэсгийн “хуулийн этгээд /төрийн өмчийн оролцоотой болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/-ийн” гэснийг “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “гэрээ байгуулсан” гэсний дараа “тохиолдолд тухайн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5.8 дахь хэсгийн “хуулийн этгээд /төрийн өмчийн оролцоотой болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/-ийн” гэснийг “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “гэрээ байгуулсан” гэсний дараа “тохиолдолд тухайн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “5.9.Иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан энэ хуулийн 5.7-д заасан хуулийн этгээдийн хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/9 дүгээр зүйлийн 9.1.16, 9.1.17 дахь заалт:

9.1.16.энэ хуулийн 5.7-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийг удирдах, хуулийн хэрэгжилтийг хангуулах бүрэн эрхт төлөөлөгчийг томилох;

9.1.17.энэ хуулийн 9.1.16-д заасан бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журмыг энэ хуульд нийцүүлэн батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйлийн 1/ заалт нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:

“5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болох бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.”

2/8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт:

8.1.7.Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох болон ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх.”

3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

9.1.5.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Ц.Цэрэнпунцаг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “холбогдуулан” гэсний дараа “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигласны үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр” гэж нэмж, мөн заалтын “2029 оны 1 дүгээр

улиралд багтаан” гэснийг төслийн 1 дэх заалтын 1.2 дахь дэд заалтын “боловсруулж,” гэсний дараа шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Монгол Улсын иргэн бүрд 2024 оны 2 дугаар улиралд багтаан хуримтлалын нэрийн данс үүсгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Хуримтлалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн дансыг Монголбанкн дахь төрийн сангийн дансанд үүсгэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, Эдийн засгийн статистикийн газрын дарга М.Оюунжаргал, Нийгмийн статистикийн газрын дарга М.Оюунцэцэг, Тооллого өгөгдлийн шинжилгээний газрын дарга Ш.Ариунболд, Нэгдсэн статистикийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Тэгшжаргал, Хөдөө аж ахуй, байгаль орчин үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга Э.Мягмарханд, Нийгмийн статистикийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваажаргал, Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн дарга Л.Ундрал, Өгөгдөл, судалгаа шинжилгээний хэлтсийн дарга Д.Оюунбилэг, Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн дарга О.Мандахзориг, Үндэсний тооцооны хэлтсийн ахлах статистикч Ж.Цэрэнханд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, мөн хорооны Нэгдсэн статистикийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Тэгшжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүй

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх Д.Намхайдагва, мөн төслийн менежер Б.Нинжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүйг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх Д.Намхайдагва танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх Д.Намхайдагва хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүйтэй танилцлаа.

Уг асуудлыг 16 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 13 минут үргэлжилж, ирвэл зохих 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
13 цаг 29 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдийнхээ ирцийг танилцуулъя. Өнөрболор гишүүн өвчтэй байна. Ингээд Цэрэнпунцаг ирсэн. Батлут гишүүн ирсэн. Баттөмөр гишүүн ирсэн. Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Ганбаатар гишүүн ирсэн. Ганибал гишүүн, Ганхуяг гишүүн Даваасүрэн, Доржханд гишүүн, Жавхлан гишүүн, Оюунчимэг гишүүн, Ундрам гишүүн, Хүрэлбаатар гишүүн, Цогтгэрэл гишүүн, Чинзориг гишүүн, Энхбаяр гишүүн, Энхтүвшин гэсэн гишүүд ирж, хурлын ирц 55,6 хувьтай бүрдэж өнөөдрийн буюу 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Дараалал шууд 1-ээс эхэлчих үү? 1-д, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газар 2024 оны 4 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг явна. 2-т, Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ, сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Монголбанкнаас 2023 оны 12 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. 3.Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны 3 сарын 27-нд ирүүлсэн хэлэлцэх, 4.Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны

тайлан, 2024 он 3 сарын 28-нд ирүүлсэн, хэлэлцэх. 5.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийг үндэслэн Байнгын хорооны санаачилгаар үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүйн талаар мэдээлэл сонсох, энэ чиглэлээр сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулах, холбогдох байгууллагын мэдээлэл сонсоно. Энэ мэдээлэл нь удахгүй орж ирэх Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэлэлцэх асуудалтай нягт холбогдох учраас та бүхнийг идэвхтэй оролцохыг уриалж байна. Ингээд энэ саяын миний дурдсан 5 асуудал хэлэлцэхээр тов дараалалд орсон байна.

Нэг. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.12.26-ны өдөр ирүүлсэн/

Үүнээс Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн саналын томъёолол бэлэн болж, яг одоогоор орж ирж амжаагүй байгаа тул эхний асуудлаас түр хойшлуулж, Эрдэнэсийн сангийн 2024 оны төсвийн тухай тогтоолоо хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг оруулаарай. Энэ хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орё. Ажлын хэсэг орчихсон уу? Ажлын хэсэг танилцуулах юм байна уу? Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны, одоо шууд ганцхан ганцхан санал байгаа. 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн төслийг Монголбанкны дэд Ерөнхийлөгч

Энхтайван танилцуулна. Энхтайвангийн микрофоныг нээе. Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

Ажлын хэсгийг танилцуулъя Ганболдын Энхтайван Монголбанкны дэд Ерөнхийлөгч, Пүрэвдоржийн Энхтуяа, Эрдэнэтуяа Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн захирал, 2 номерын микрофоныг нээе.

Г.Энхтайван: Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьж байна. 2023 онд Монголбанкны Эрдэнэсийн сан 17,8 тонн үнэт металл худалдан авч, гадаад валютын улсын албан нөөцийг 788,4 сая доллароор нэмэгдүүллээ. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого зарлагын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гаргалаа.

Үүнд 1.Монголбанкны Эрдэнэсийн санд 2 тэрбум төгрөгөөр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн төрц худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологийн олдворыг сэргээн засварлах ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг хийхээр төсөвлөсөн бөгөөд төсвийн гүйцэтгэлд 110 сая төгрөг байна. 2.200 ширхэг дурсгалын зоосны дээжийг үндсэн санд орлогод авахаас 276 ширхгийг орлогод бүртгэгдсэн байна. 3.Чингис хааны алтадсан хүрэл баримлыг бүтээлгэх зардлын төсөв 8 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 8,9 тэрбум төгрөг байна. 4.Чингис хааны хүрэл баримлыг алтдах, алтан тамгыг бүтээлгэхэд 150кг алтыг зарцуулахаар төсөвлөснөөс

111,6кг алт буюу 6,5кг алтаар баримлыг бүрж, 99,6кг алтыг алтан тамгад зарцуулан 2023 оны 10 дугаар сарын 3-ны өдөр хүрэл баримал, алтан тамгыг Монгол Улсын Эрдэнэсийн сан болон Чингис хаан музейд хүлээн авч, эрдэнэсийн сангийн Үндсэн сангийн байнгын бус хэсэгт Алтан тамгыг хөрөнгөөр бүртгэж авсан. 5.Гүйлгээ сангаас 23950 ширхэг дурсгалын зоос болон алтан, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар тусгагдсанаас зочин төлөөлөгчийн зардлаар 174 ширхэг дурсгалын зоос, 6570 ширхэг дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, мөнгөн үрлийг худалдаалсан байна.

2024 оны Эрдэнэсийн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын төсвийн төслийг та бүхэнд танилцуулъя. Монголбанкнаас Эрдэнэсийн сан хөмрөгийг 2024 онд дараах байдлаар нэмэгдүүлж, үндсэн санд орлогоор бүртгэхээр төлөвлөж байна. Үүнд, 1.Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, байгалийн төрц худалдан авах, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад 2 тэрбум төгрөгийг зарцуулах. 2.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн хүрээнд гүйцэтгэж буй Чингис хааны хүрэл баримлыг тээвэрлэх, угсралт, гэрэлтүүлэг, бусад ажлын зардалд нийт 1,5 тэрбум төгрөг зарцуулах. Мөн Үндсэн сангийн байнгын бус хэсэгт хөрөнгөөр бүртгэх. 3.Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж, 100 ширхгийг хүлээн авч, орлогоор бүртгэх. 4.Тэнцлийн гадуурх данснаас 2018 оны 5000 төгрөгийн загвар 2 ширхгийг, Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкны мөнгөний чек 1 ширхгийг, 1938 оны 2 төгрөг 50 мөнгөний вексель 1 ширхгийг Үндсэн сангийн байнгын бус хэсэгт ишлжүүлэн бүртгэх. 5.Мөнгөн тэмдэгтийн газраас ишлжүүлэн хүлээн авсан 20 мянган төгрөгийн мөнгөний хэв 1 ширхгийг

Үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэх. 5, 6. Гүйлгээ санд 2024 онд үйлдвэрлэх дурсгалын зоос болон бусад эд зүйлсийг орлогоор бүртгэнэ. Мөн гүйлгээ сангаас 24550 ширхэг дурсгалын зоос болон гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар тусгагдсанаас худалдаалах зориулалтаар 24350 ширхгийг, зочин төлөөлөгчийн зардлаар 200 ширхэг дурсгалын зоос зарцуулахаар тусгалаа.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын хүрээнд Монголбанк, Соёлын яам, Чингис хаан музейтэй 05 23/244 дугаартай Чингис хаан үндэсний музейд үзэсгэлэн зохион байгуулахад хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд Чингис хаан музейн хүндэтгэлийн танхимд Чингис хаан хүрэл баримлын үзэсгэлэнг зохион байгуулах дэглэлтийн зардалд 2,9 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөж байна.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Эдийн засгийн байнгын хорооны хурлаар 2 мянга, Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2024 оны төсвийн төслийг хэлэлцэж өгөхийг хүсье.

Ц.Цэрэнпунцаг: Энхтайванд баярлалаа. Танилцуулгатай холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ганбаатар гишүүн та юунд микрофон, юун дээр дараарай, ороод ирсэн. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуултаа асууж, саналаа хэлье.

С.Ганбаатар: Баярлалаа. Монголбанк дээр нөгөө төвлөрөөд байгаа мөнгөний үлдэгдэл ер нь хэд байгаа юм бол? Хэдэн их наядад хүрсэн бол? Би бас тэр нэршлийг нь бас хуулийнх нь дагуу мартсан байна. Тэрийг хэлж өгөөч.

2 дугаарт энэ бодлогын хүү одоо 13 хувьтай, 12 билүү байгаа. Тийм. Тэгээд зээлийн хүү энийг дагаад одоо маш их өндөр байна л даа. Хадгаламж гэхэд л одоо 16 хувьтай, 19 хувьтай. Тэгээд энэ одоо ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүс энэ их өндөр зээлийг төлөөд одоо яах боломж байхгүй байна. Монголбанк энэ дээр ямар бодлого барих вэ? Би одоо ер нь Эдийн засгийн байнгын хороон дээр Монголбанк орж ирэх болгонд л асууж байгаа л даа. Тэгээд 5,5 их биш ээ, тэрбум долларын юутай нөөцтэй болчихсон гэж байгаа юм. Би нэг дээр нэг Засгийн хуралдаан дээр танай Ерөнхийлөгчөөс асуухад 4 тэрбум долларын нөөцтэй болбол бодлогын хүү буцаад одоо таны Эдийн засгийн байнгын хороон дарга байх үеийн хэмжээнд хүрнэ гээд хариулсан юм. Тэгээд тэрнээс хойш одоо ингээд валютын нөөц 4 их юу, 4 тэрбум биш 5 тэрбум, тэгээд 5-аас дээш болчихлоо. Энэ бол гол үүрэг нь бас биржийг энэ нүүрсийг биржээр зарсантай холбоотой л доо. Одоо SCX коллын үнээр л бараг бирж өөрөө зарж байна шүү дээ, 400 доллар нүүрс байхад 60-хан доллароор зарж байсан бол өнөөдөр одоо шинэчлэлийн үр дүнд Их Хурал, Засгийн газар бүүр хамтраад маш том шинэчлэлүүдийг хийсэн. Энэний үр дүнд яг CSX коллын үнээр л манай бирж нүүрсээ зарж чадаж байгаа юм. Тэгээд энэний нөлөөнд бас валютын нөөц нэмэгдэж байгаа.

Тэгэхээр энэ бодлогын хүү одоо өндөр байгаагаас болоод энэ эдийн засагт ирж байгаа том, том тоонууд хүний амьдралд наалдахгүй байна. Яг иргэдийн амьдралд наалдахгүй байна. Тэгэхээр Монгол банк ер нь ямар бодлого барьж байгаа бол? Монголбанкнаас явуулж байгаа бодлого, Энхтайван Ерөнхийлөгч бас мэдэж байгаадаа байнга л ярьдаг. Тэгээд энийг ер нь, хүн чинь ер нь тэгээд л ажил хийж байж л, хөдөлмөрлөж байж л амьдарна. Нийгэм ч гэсэн, худлаа яриад байгаа бол тэр урт насгүй л дээ. Шүүмжлэл хэлээд л, худлаа яриад л байгаа бол урт насгүй. Тэгээд л

нэг түр зуурын аргацаасан нэг тийм юм болно. Тэгэхээр ажил хөдөлмөр хийж байгаа, хөдөлж байгаа хүмүүсээ дэмжихийн тулд наад зээлийн хүү зохих ёсондоо хүрэх л хэрэгтэй байна л даа. Хадгаламж хэтэрхий өндөр байна, зээлийн хүү их тэрийгээ дагаад бас их өндөр байна л даа. Тэгээд нэг дорвитой хариултыг өгчих гэж л хүсье. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 2 номер хариулъя.

Г.Энхтайван: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2024 оны 1 дүгээр улирлын төгсгөлийн байдлаар Төв банкн дээрх Төв банкны үнэт цаасны үлдэгдэл бол 9,8 их наяд төгрөгтэй байгаа. Бодлогын хүү бол 12 хувьтай байгаа, 12 хувь гэдэг маань 3 дугаар сард бол бид бүхэн мөнгөний бодлогын хүүг бол 1 хувиар бууруулсан. Энэ нь бол одоо сүүлийн одоо жил гаруй хугацааны дараа анх удаа одоо бодлогын хүү бол 13 хувиас бол доошилж байгаа. Бодлогын хүү маань өөрөө Төв банкны одоо хуулиар олгогдсон үндсэн мандат болох үнийн тогтвортой байдлыг хангах, Монгол Улсын үндэсний валют, мөнгөн тэмдэгтийн төгрөгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд бол инфляцыг бид бүхэн дунд хугацаанд тогтворжуулах бодлого барьдаг. Яг энэ хүрээнд инфляцын нөлөөтэй холбоотойгоор бол бодлогын хүүг бууруулсан байгаад байгаа. Инфляц бол ойролцоогоор бол 2024 оны 3 дугаар сарын байдлаар бол 7 хувьтай гарсан. Энэ бол яг оргил одоо 16,8 хувьд хүрч байснаасаа бол даруй 9,8 хувиар бол буурчхаад байгаа.

Бодлогын хүү бол буурах асуудал бол инфляцаас бол бүрэн хамааралтай. Инфляцыг Төв банкны зорилтот түвшин буюу 6+, - байна гээд энэ оны төгсгөлөөр одоо тогтворжуулсны үеэр бол бодлогын хүүг бол дахин бол бууруулах боломжтой бол гэж үзэж байгаа. Бодлогын хүүтэй уялдуулаад бол арилжааны банкнуудаас олгогдож байгаа зээлийн хүү бол тогтоож байгаа.

Зээлийн хүү бол өөрөө одоо тухайн Монгол төгрөгийн үнэ цэн гэсэн үг шүү дээ. Үнэ цэн гэсэн үг. Тэгэхээр бол мэдээж бид бүхэн хуулиар олгогдсон төгрөгийн үнэ цэн гэдэг маань нөгөө талдаа бол зээлийн үнэ цэнтэй бас салиггүй холбоотой байгаад байгаа. Гадаад валютын албан нөөц бол 3 дугаар сарын төгсгөлөөр 1 дүгээр улирлаар бол 5,2 тэрбум доллар бол хүрсэн. Энэ болбол түүхэн дээд дэмжье. Гэхдээ бид бүхэн бас гадаад валютын нөөцтэй холбогдуулаад гадаад валютын хүрэлцээтэй байдал гэдгээ бас давхар бодож байх хэрэгтэй. Урьд нь бол одоо 2019, 2020 онд одоо 5 тэрбум доллар гэдэг маань өөрөө 13 сарын импортын хэрэглээг хангах хэмжээний нөөц байсан бол одоо импорт огцом нэмэгдсэний хүрээнд бол энэ бол дөнгөж 6,8 сарыг л хангаж байгаа. Тэгэхээр бол импортын 6,8 сарын хэрэглээг хангах нөөц гэдэг маань бол одоо юу бид бүхэн бол гадаад валютын албан нөөцийг бол дахин нэмэгдүүлэх бол зайлиггүй шаардлагатай байгаа л гэсэн үг.

Гадаад валютын албан нөөц нэмэгдэж байгаа үндсэн шалтгаан бол энэ экспортын орлогоос хамааралтай. Өнгөрсөн одоо 2023 онд бол гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан, төлбөрийн тэнцэл 1 тэрбум доллар давсан ашигтай гарсан. Энэ бол уул уурхайн бараа, бүтээгдэхүүнийг бол биржээр арилжаалсан экспортын орлого бол нэмэгдсэн нийтдээ бараг 12 тэрбум доллар давсан экспортын орлоготой байснаас бол хамаарч байгаа. Гадаад валютын албан нөөц нэмэгдээд явсны хүрээнд бол энэ нь өөрөө Төв банкн дээр гадаад валютын албан нөөцөөс хамаарсан гадаад цэвэр активаас хамаарсан мөнгөний нийлүүлэлт бол нэмэгдэж байгаа. Энэ хүрээнд бол экспортын орлогоос хамааралтайгаар бол бодлогын хүү эдийн засаг тогтворжуулах үйл ажиллагаанд бол экспортын үйл ажиллагаанаас хамааралтай байгаад байгаа. Хэрвээ энэ хэвээрээ үргэлжлээд

явах юм болбол одоо бодлогын хүү үүнээс одоо буурах бол боломжтой байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Би асуухгүй ээ, 1 минутаа ашиглаадахъя. Энэ тэгэхдээ та яг тоогоо хэлэх тусам тоондоо бол яг бодлогын хүү буух ёстой гэдгээ л хэлээд байна. Түүхэн дээд хэмжээнд хүрсэн валютын нөөцтэй, инфляц 7 хувьд хүрсэн. Тэгсэн мөртөө бодлогын хүү нь түүхэн дээд хэмжээндээ хүрчихсэн. Тэгээд нэг юмнаас болгоомжлоод байгаа юм уу, эсхүл нэг юмыг эсхүл шийдвэр гаргаж чадахгүй байгаа юм уу, эсхүл нэг хариуцлагаас зугтаад байгаа юм уу? Тэгээд хэлж байгаа тоонууд чинь бол ерөөсөө өөрөө яг бодлогын хүүг буулгах ёстой л гэдэг хэлээд байна шүү дээ. Тэгээд энэ чинь цаанаа өөрөө хүн хөдөлмөр хийх сонирхолгүй зүгээр хадгаламж одоо өгөөд л, эсхүл банкнуудын нөлөөнд автаж байна л гэж би бол одоо тэгж л үзнэ. Тийм байдалтай харагдаж байна шүү. Тэгээд наад банкнууд чинь хараач, түүхэн дээд хэмжээнд хүрчихсэн, бүүр 10 их наядын үлдэгдэлтэй байна шүү дээ. Тэгээд наадах чинь уул нь эдийн засагт эргээж байх ёстой шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Монгол Улсын Эрдэнэсийн сангийн 2023 оны орлого, зарлагын гүйлгээг харж байна. Энэ 1.1 дээр энэ Чингис хааны баримал, алтан тамганы хамт бүтээлгэх гээд 8 тэрбум төгрөг батлагдсанаас 8,9 тэрбум төгрөг одоо зарцуулсан байна гээд 900 гаруй сая төгрөгийг илүү зарцуулсан байна. Тэгээд нэгэнт одоо батлагдсан төсөв юм чинь батлагдсан төсвийнхөө хүрээнд ийм зардал гаргах ийм бололцоо боломж байгаагүй юм уу? Яагаад энэ 900 гаруй сая төгрөгийг илүү зарцуулчав гэдэг нэг асуудал асуумаар байна.

2 дахь асуудал бол энэ Чингис хааны баримал, алтан тамганы хамт бүтээлгэх гээд энэ чинь ер нь ямар үнэтэй юм, нэг нь одоо ямар үнээр гарсан юм, хэдэн төгрөгийн үнэт металл гарсан юм, хэдэн төгрөгийн алт гарсан юм гээд бас нэг тодорхой байхгүй бол энэ чинь мэдээлэл чинь бол ер нь нэг зүгээр мэдээллийн чанартай л ийм зүйл байгаад байна шүү дээ. Хэрвээ одоо энэ төсвийн байгууллага ч гэдэг юм уу, Засгийн газрын дэргэдэх энэ агентлагууд төсвөө батлагдсан төсвөө илүү зарцуулах юм бол ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээдэг. Тийм учраас энэ 900 сая төгрөгийг яагаад илүү зарцуулчав? Ямар эрх зүйн акт бий болоод, ямар хүчин нөлөөлөөд ингээд илүү зарцуулчав гэдэг дээр энэ дээр нэг асуулт асуумаар байна.

Ц.Цэрэнпунцаг: Тодорхой асуулт асуулаа, 2 номер хариулъя. Энхтайван.

Г.Энхтайван: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн одоо 2022 оны 02 дугаар зөвлөмжийн дагуу Чингис хааны алтадсан хүрэл баримал, алтан тамгыг бол Монгол Улсын Соёлын яамтай хамтран одоо бүтээлгэх ажлыг Төв банк хариуцаад явж байгаа. Энэ хүрээнд өнгөрсөн жил батлагдсан төсвөөс 900 сая төгрөгөөр бол давсан байна гэдэг асуудлыг Энхтүвшин гишүүн хөндлөө. Энэ тусгай ачаа учраас энийг бол бид бүхэн энэ одоо 7 метрийн өндөртэй энэ Чингис хаан баримлыг бол тусгай үүргийн онгоцоор тээвэрлэж авчирсан байгаад байгаа. Тэгэхээр тусгай үүргийн онгоцоор тээвэрлэх зардал дээр бол энэ одоо төсвийн энэ хэтрэлтийн асуудал бол байгаа. Гэхдээ энэ маань энэ баримал маань өөрөө 3 төсвийн 3 жил дамнаад явж байгаа 22, 23, 24 онд. Тэгэхээр бол яг төсвийн өөрийнх нь одоо баримал бүтээлгэх зардлаас бол хэтрэхгүй байгаа. Гааль, НӨАТ-ын татварын нэмэгдэл, мөн тээвэрлэлтийн зардалтай холбоотой бол энэ 900 сая төгрөг нэмэгдсэн байгаад байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Т.Энхтүвшин: Ойлголоо, ойлголоо. Энэ гааль, ачаа тээврийн үнэ бас нэмэгдсэнтэй холбогдуулаад бас энэ тээврийн зардалтай холбогдуулаад энэ төсөв бас хэтэрсэн байна гээд. Тэгээд энийгээ тухайн жил нь ч гэдэг юм уу төсвийн тодотголд эд нар оруулаад явдаг зүйл одоо байдаг юм уу, байдаггүй юм уу? Одоо Монголбанкны төсөв одоо яаж батлагддаг юм бэ? Тэгээд энийг төсвийн тодотголд оруулаад ингээд залруулаад явах ийм бололцоо боломж 1 дүгээрт бас байсан юм байна гээд.

2 дахь асуудал бол энэ Баттөмөр гишүүний бас өргөн барьсан хууль байгаа шүү. Энэ Монгол, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах гээд. Энэ асуудал дээрээ та хэд нэг жосоохон идэвхтэй санаачилгатай ажилламаар байна. Одоо ингээд гацчихаад байна шүү дээ. Энэ Байнгын хороон дээр гацчихаад байна. Үнэхээр одоо юу гэдэг юм энийг нэмэлт, өөрчлөлт оруулахгүй гэж байгаа бол та хэд Банкны тухай хуульд заасан тэр одоо хориг арга хэмжээ ч гэдэг ч гэдэг юм уу тэр Монголбанкнаас хэрэгжүүлээд явах юмнуудаа яаралтай хэрэгжүүлээд явах хэрэгтэй. Үнэхээр одоо энийг яаралтай өөрчлөлд ингээд банкнуудыг олон нийтийн болгох энэ ажлаа үргэлжлүүлээд хийгээд.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Санал хэллээ Энхтүвшин гишүүн. Гишүүд асуулт асууж, хариулт, саналаа хэлж, хариулт авч дууслаа. Ингээд санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 60

хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулна. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

13.49 цаг

Хоёр. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлан

Дараагийн асуудалдаа орёе. Та буцаж орж ирнэ биз? Хэлэлцэх дараагийн хэлэлцэх асуудал Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье. Тайлангийн танилцуулгыг, ажлын хэсгийг оруулаарай. Тайлангийн танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Хүдэрчулуун хийнэ. Ажлын хэсэг суудлаа эзлээрэй. Хүдэрчулуун дарга ажлын хэсгийн 2 номер дээр суучих. Хүдэрчулуун дарга хаана байна вэ? Хүдэрчулуун дарга тэр ажлын хэсгийн 2 номер дээр суугаад шууд танилцуулгаа хийгээдэх, танилцуулгаа.

Н.Хүдэрчулуун: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны тайлан 2023 оны үйл ажиллагааны тайланг товч танилцуулъя. Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд 2023 онд 9 газар, 5 хэлтэс, 6 алба нийт 168 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ажиллалаа. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг нэмэгдсэнтэй холбоотойгоор Сэндбоксын алба, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэлтэс, Мөнгөн зээлийн

зохицуулалтын албыг тус тус байгуулан ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой нийт 29 хууль, 139 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 23 онд шинээр 6, нэмэлтээр 6 журамд өөрчлөлт оруулан баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн байна. Эдгээр 139 дүрэм, журмыг зохицуулалтын салбараар авч үзвэл үнэт цаасны зах зээл дээр 66, даатгалын зах зээл дээр 25, банк бусын санхүүгийн байгууллагын салбарт 19, хадгаламж, зээлийн хоршооны салбарт 6, үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын салбарт 7, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарт 6, бусад салбарууд дээр нийт 10 ийм дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хороо хангуулан ажиллаж байна.

Хорооны Санхүүгийн зохицуулах хорооны үндсэн үйл ажиллагаа бол хорооны хуралдаан байдаг. Санхүүгийн зохицуулах хорооны дүрмээрээ сард 2 удаа, 2-оос доошгүй удаа хуралдах ийм зохицуулалттай. 23 онд нийт Санхүүгийн зохицуулах хороо 24 удаагийн хуралдаанаар 810 тогтоолыг баталж гаргасан байна. Эдгээрийг салбаруудаар авч үзвэл үнэт цаасны зах зээлийн салбарт 132, даатгалын салбарт 34, банк бус санхүүгийн байгууллага болон мөнгөн зээлийн үйл ажиллагааны салбарт 108, хяналт шалгалтын зохицуулалтын салбарт 68, хууль, эрх зүйн салбарт 9, үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын салбарт 343 зэрэг эдгээр хуралдаанаас гарсан тогтоолын тогтоол гарсан байна.

Улсын Их Хурлаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 оны 11 сарын 17-ны өдөр батлагдсан байдаг. Ингээд 2006 оноос санхүүгийн үндсэн 4 салбар бол хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл,

банк бус санхүүгийн байгууллагын салбар, хадгаламж зээлийн хоршооны гэсэн ийм үндсэн 4 салбарт Санхүүгийн зохицуулах хороо үйл ажиллагаагаа явуулдаг байсан. 2020 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбар болох үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгийн зуучлал, үнэт металл, үнэт чулууны эсвэл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн энэ салбарыг зохицуулахаар тусгасан байгаа.

21 онд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор системийн нөлөө бүхий банкнуудыг олон нийтийн нээлттэй компани болгох энэ ажлуудыг хэрэгжүүлснээр системийн нөлөө бүхий банкнууд хувьцаат компани хэлбэртэй болж Санхүүгийн зохицуулах хорооны бас хяналт шалгалтад бас орсон байгаа. Мөн сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах, мөн Санхүүгийн зохицуулах хорооны санаачилгаар Монгол Улсын Санхүүгийн хүртээмжийн үндэсний хөтөлбөрийг баталсан байж байгаа. Энэ хөтөлбөрийн гол үндсэн зорилго болбол технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх замаар ард иргэдэд, аж ахуйн нэгжүүд бүрд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэгжүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ гэсэн ийм үндсэн чиг үүрэгтэй. Энэ хүрээндээ сэндрокс зохицуулалтын орчныг бий болгож, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2021 оны хамтарсан тушаалаар энэ сэндроксын зохицуулалтын орчныг бас бий болгосон байгаа. Мөн 22 онд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдаж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэж, тэдгээрийн хяналт зохицуулалтыг хийхээр ийм тусгасан өөрчлөлт орсон.

2023 оны Улсын Их Хурлаар баталсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль тус тус батлагдсанаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хяналт, зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцахаар тус тус зохицуулсан байгаа. Энэ 2020 онтой харьцуулаад үзэхэд Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын чиг үүрэг, хамрах хүрээ болбол бараг 3 дахин нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл, цоо шинэ Монгол Улсад урьд өмнө огт зохицуулагдаж байгаагүй нийт 7 салбарын үйл ажиллагааг зохицуулах ийм үүргийг хуулиар хүлээсэн байж байгаа. Энэ хүрээндээ шинэ энэ 7 салбарын одоо санхүүгийн болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх энэ эрсдэлийн үнэлгээнүүдийг хийж, эдгээрийн эдгээр салбаруудын хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллаж байна.

Хамрах хүрээ нэмэгдсэнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай этгээдийн тоо бол жил ирэх тусам нэмэгдэж байна. 2019 онтой харьцуулахад 54,8 хувиар зохицуулалттай этгээдийн тоо өссөн гэсэн ийм статистик үр дүн байна. Тэгэхээр эдгээр зохицуулалттай этгээдүүдийг нийт хамрагдах энэ санхүүгийн салбаруудаар нь аваад үзвэл хөрөнгийн зах зээл дээр 603, үл хөдлөх хөрөнгө, эд хөрөнгийн зуучлалын салбарт 308, үнэт металлын салбарт хувь хүн 428, хуулийн этгээд 52, хадгаламж, зээлийн хоршооны салбарт 191, виртуал хөрөнгийн салбарт 12, сэндбокс зохицуулалтын орчинд нийт 7, даатгалын салбарт 337, банк бус санхүүгийн байгууллагын салбарт 509, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх 23 оны жилийн эцсийн байдлаар 7 этгээд бүртгэгдсэн байсан бол өнөөдрийн байдлаар 42 этгээд бүртгэгдсэн ийм дүнтэй байна. Тэгэхээр жилээс жилд нэмэгдэж байгаа энэ зохицуулалттай этгээдийн тоо нэмэгдэж байгаа нь нэг талаасаа болбол шинээр хуулийн хүрээнд

орж ирж байгаа зохицуулалтын салбарууд болон тухайн салбар бүр дээр орж байгаа өргөжилтийн бас үр нөлөө байгаа гэдгийг бас энд хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Ингээд 23 онд хийгдсэн бодлого, зохицуулалтын онцлох арга хэмжээнүүдээс товчхон танилцуулъя. Улсын Их Хурлаас Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан банкны реформ, төрийн өмчит компаниудын хувьчлалыг амжилттай хэрэгжүүлэх энэ алхмуудыг энэ 23 онд бас хийж гүйцэтгэлээ. Нийт 6 банкны IPO хийгдсэн байна. Энд хөрөнгийн зах зээл, зах зээлийн үнэлгээ 5,9 их наядаар нэмэгдэж 2,2 дахин нэмэгдсэн. 6 банкны хувьд нийт 72 мянга гаруй хөрөнгө оруулагчдаас 478,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн ийм үр дүнтэй байна.

Мөн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн дуудлага худалдаагаар арилжсан нүүрс, төмрийн хүдэр, баяжмалын үнийн өсөлт дунджаар 10 хувьтай байна. 1 тонн бүтээгдэхүүний хаалтын хани 220-оос 1330 юань, 64-өөс 180 долларын хооронд хэлбэлзсэн ийм дүнтэй байна. Мөн хөрөнгө оруулагчдыг дэмжсэн татварын эрх зүйн орчныг бас бүрдүүллээ. Улсын Их Хурлаас 24 оны төсвийн тухай хуулийг хуулийн төслийг дагалдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон байж байгаа. 24 оноос гадаадын хөрөнгө оруулагчдын албан татварт ноогдох орлогыг дотоодын хөрөнгө оруулагчтай ижил тэнцүү, ялгаваргүй байдлаар суутган тооцох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас үл хамааран үнэт цаас борлуулсны орлогод ноогдох албан татварыг 24-өөс 26 онд 90 хувиар, 27-гоос 29 онд 50 хувиар тус тус хөнгөлөх ийм хуулийн зохицуулалтуудыг бас бий болгоод энийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Мөн анхны хамтын биржээр арилжаалагддаг сан энэ онд бас бүртгэгдлээ. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан Компанийн өрийн хэрэгслийг бүртгэх журмын ногоон бонд гаргах зохицуулалтыг бий болгосноор Монгол Улсад анх удаа нэг бүр нь 100 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 170 мянган ширхэг бонд гаргаж, олон нийтээс 17 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн ийм дүнтэй байна. Мөн Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зохицуулах тухай хууль хэрэгжиж, нэр бүхий 5 журмыг баталсан. Одоогийн өнөөдрийн байдлаар 42 хуулийн этгээдийг бүртгээд байна. Мөн Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай хууль, Даатгалын зуучлалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгуудын төслийг боловсруулаад үзэл баримтлалыг батлуулсан. Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Өчигдөр Ерөнхий сайдын дэргэдэх Зөвшөөрлийн үндэсний зөвлөлөөр ороод энэ асуудал маань дэмжигдсэн. Тэгээд удахгүй бас Монгол Улсын Засгийн газраас Их Хуралд өргөн мэдүүлэх энэ ажлууд нь бол хийгдэх байх гэсэн ийм хүлээлттэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны бас нэг үндсэн чиг үүрэг нь энэ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх энэ чиглэлд бас үйл ажиллагаагаа чиглүүлж ажилладаг. Өнгөрсөн 23 оны 7 дугаар сард ФАТФ-ын техникийн зөвлөмжийг бүрэн ба дийлэнхийг нь хангаж биелүүлсэн Монгол Улс бүс нутгийн хэмжээнд анхны, дэлхийн хэмжээнд 5 дахь орон болж болсон байж байгаа. Тэгэхээр цаашид энэ техник, хэрэгжилтийн энэ зөвлөмжүүдийг илүү их ахиулах, сайжруулах чиглэлээр бол Санхүүгийн зохицуулах хороо онцгой анхаарч ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Мөн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, ази

номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, дотоодын аж ахуйн нэгж, компаниудыг гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн б... гаргах, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Хонконг, Шанхайд бас цуврал арга хэмжээнүүдийг зохион байгуулж байгаа. Энэ арга хэмжээ ч гэсэн энэ онд бас үргэлжлээд явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байна. Түрүүн бас хэллээ. Энэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих замаар санхүүгийн салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн ийм гол үндсэн концепцыг бас Санхүүгийн зохицуулах хороо бас хэрэгжүүлдэг. Энэ хүрээндээ санхүүгийн салбар дахь инновацыг дэмжих, олон нийтэд технологид суурилсан санхүүгийн зах зээл болон энэ сэндбоксын зохицуулалтын орчныг таниулах зорилгоор текспринт гэдэг энэ олон улсад шинэ хөгжиж байгаа энэ уралдааныг бас зохион байгуулсан анх удаа Монголд. Тэгэхээр энд нийт 22 багийн 100 гаруй ийм оролцогчид оролцсон ийм бас өргөн олон нийтийг хамарсан ийм арга хэмжээ болсон байж байгаа. Цаашид яг эндээс гарч байгаа шинэ санаа санаачилгыг илүү практикт нэвтрүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо бас идэвх гаргаж ажиллана гэсэн ийм зорилготой бас ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны энэ зохицуулалттай этгээдүүдийн энэ Монгол Улсын эдийн засагт гүйцэтгэх үүргийн талаар бас товчхон тоон статистик хэлье. 2020 онд нийт Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай этгээдүүдэд хамаарагддаг энэ 4 салбарын хувьд 2020 онд 15,3 хувьтай дотоодын нийт бүтээгдэхүүний 15,3 хувьтай тэнцэх хэмжээний ийм зах зээл байсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 24,9 хувийг эзэлдэг ийм зах зээл болсон байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого сүүлийн 30 гаруй жилийн гол үндсэн тавигддаг зорилго болбол

санхүүгийн зах зээлийг илүү олон тулгуурт ийм зах зээл болгоно гэсэн ийм зорилтуудыг тавьдаг. Энэ зорилт бас биелэгдэх суурь нөхцөлүүд бас бий болж байгаа гэдгийг энэ статистик үзүүлэлтүүд бас харуулж байна. Тайлант онд нийт даатгал, банк бус санхүүгийн байгууллага, энэ хадгаламж зээлийн хоршооны салбар болон үнэт цаасны компани зэрэг эдгээрт бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон хүн амын орлогын албан татварт 93,1 тэрбумыг, нийгмийн даатгалын шимтгэлд 80,1 тэрбум төгрөгийг бас татан төвлөрүүлсэн байна.

Ингээд салбар тус бүрээр нь тодорхой тоон статистикуудыг бас хэлье. Хөрөнгийн зах зээлийн нэг гол тодорхойлогч үзүүлэлт бол энэ хөрөнгийн зах зээлийн үнэлгээ гэдэг ийм үзүүлэлт байдаг. Сүүлийн 4 жилийн хугацаанд нийт хөрөнгийн зах зээл дээр 80 гаруй цоо шинэ бүтээгдэхүүн бий боллоо. Түрүүн бас дурдсан Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан тодорхой хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээнд, Санхүүгийн зохицуулах хороо тодорхой эрх зүйн шинэтгэлүүдийг хийсний хүрээнд зах зээлийн үнэлгээ 11,6 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь 2020 онтой харьцуулахад 69,1 хувиар өссөн ийм дүн байна. Нийт 594,9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээл дээр арилжаалагдсан ба арилжааны нийт арилжааны 52,9 хувийг хувьцаа, 23,1 хувийг компанийн бонд, 17 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 0,7 хувийг Хөрөнгө оруулалтын сан тус тус эзэлж байна.

Мөн биржийн бус зах зээлийн арилжааг анх 2021 оны 9 дүгээр сард анхны өрний хэрэгслээ бүртгэж, үйл ажиллагаагаа эхэлснээс хойш өнөөдрийн байдлаар 2,4 их наяд төгрөгийн өрний хэрэгслийг бүртгэж, 1,7 их наяд төгрөгийн татан төвлөрүүлсэн ийм дүнтэй байна. Мөн доллароор 71 сая ам.долларын өрийн хэрэгслийг бүртгэж, 45,5 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн ийм дүнтэй байна.

Хөрөнгийн зах зээлийн бас нэг гол тодорхойлогч үзүүлэлт болбол энэ Top 20 индекс байж байгаа юм. Top 20 индекс 2023 оны хаалтын хани 41437,7 нэгжид хүрсэн бөгөөд зах зээлийн үнэлгээг салбараар нь ангилж харах юм бол аж үйлдвэрийн салбар 34,6 хувь, уул уурхайн салбар 23,1 хувь, банк санхүүгийн салбар 38,7 хувь, худалдаа үйлчилгээ 2 хувь, харилцаа холбооны салбарт 1,6 хувийг тус тус эзэлж байна. Арилжаанд оролцсон хөрөнгө оруулагчийн тоог аваад үзвэл дотоодын аж ахуйн нэгж 2188 буюу 49,5 хувь, дотоодын иргэн 108343 буюу 48,3 хувийг, гадаадын иргэн 723 буюу 1,3 хувийг, гадаадын аж ахуйн нэгж, гадаадын иргэн 0,9, гадаадын аж ахуйн нэгж 235 буюу 1,3 хувийг тус тус эзэлж байна.

Даатгалын зах зээлийн талаар товч статистик хэлье. Даатгалын салбарт нийт хөрөнгө өмнөх оныхоос 16,1 хувиар өсөж 551,4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт нөхөн төлбөрийн хувьд 94,3 2 тэрбум төгрөг ба түүний 29,5 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал эзэлж байна. Даатгалын гүнзгийрэлт 0,5 хувьд хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад бас тэг аравны, 0,05 функтээр буурсан байна. Энэ нь болбол сүүлийн 30 жилийн ер нь дундаж статистик үзүүлэлтдээ байгаа гэсэн ийм дүнтэй байна. Даатгалын нягтралын хувьд 2023 онд 115 мянган төгрөг болж 2022 онтой харьцуулахад 31,4 хувиар, 19 онтой харьцуулахад 90,1 хувиар өссөн ийм статистик үзүүлэлтүүд байна.

Банк бус санхүүгийн байгууллагын хувьд нийт банк бус санхүүгийн салбарт 23 оны байдлаар 529 банк, санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Нийт хөрөнгө өмнөх оныхоос 32,5 хувиар өсөж 4,7 их наяд төгрөгт хүрсэн ийм дүнтэй байна. Давхардсан тоогоор нийт харилцагчдын тоо 4,5 сая төгрөгт хүрсэн бол үүний 94,1 хувийг финтекийн харилцагч эзэлж байна. Зээлдэгчдийн тоо 1,6 сая болсон бол тэдгээрийн 82,4

хувийг финтекийн зээлдэгч тус тус эзэлж байна.

Хадгаламж зээлийн хоршооны салбарт нийт 191 хадгаламж зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Нийт 72521 гишүүдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаагийн 52,3 хувь нь Улаанбаатар хотод, 49,7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн хүртээмжийн үзүүлэлтээс харвал баруун бүсэд дийлэнх нь буюу 48 хадгаламж зээлийн хоршоо салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна гэсэн ийм статистик мэдээлэл байна.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт эдлэл, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэлтийн салбар нийт 2,2 их наядын үл хөдлөх хөрөнгийг худалдахад, 178,1 тэрбум төгрөгөөр хөлслүүлж түрээслүүлэхэд тус тус зуучилсан байна. Мөн Монголбанкны 2020-оос 23 оны нийт 84,9 тонн үнэт металл худалдан авсан байна. Үүнээс 31,7 тонн буюу 37,3 хувийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үнэт металл, үнэт чулууны, эсвэл тэдгээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэд, аж ахуйн нэгжээс худалдан авсан гэсэн ийм статистик мэдээлэл байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын статистикаас товчхон дурдъя. Нийт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч буюу виртуал хөрөнгийн зах зээл дээр дотоодын зах зээлийн үнэлгээ болбол 241,9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна. Өдөрт дунджаар 150 аравны, 150 сая төгрөгийн арилжаа хийгдэж байна. Баталгаажуулалт хийгдсэн харилцагчдын хувьд нийт 31-ээс 45 насныхан буюу насных нь дийлэнх нь буюу 50,7 хувийг эзэлдэг. 16-аас 30 насныхан болбол 42 хувийг тус тус эзэлж байгаа гэсэн ийм статистик үр дүнтэй байна. Нийт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч энэ салбар дээр үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос энэ шинээр бий болгосон нэг зохицуулалт бол энэ сэндбокс зохицуулалтын орчин байж байгаа. Сэндбокс зохицуулалтын орчин бий болсноос хойш нийт 7 шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний туршилтыг амжилттай хийж хэрэгжүүлж байна. Үүн дотроо хамтын санхүүжилт буюу краудфандингийн чиглэлээр нийт 64,6 сая төгрөгийн санхүүжилтийг татсан ийм дүнтэй байна. Мөн зээлийн платформоор дамжиж 5485 харилцагчийн P2P зээлийн үйлчилгээг хүртсэн байна. Репо хэлцлийн зуучлалын платформоор дээр нийт 35 зээлдэгч зээлдүүлэгч, 31 зээлдэгч оролцсон нийт 179,7 тэрбум төгрөгийн 972 удаагийн арилжаа бас хийгдсэн ийм дүнтэй байна. Мөн insurtech үйлчилгээний платформд бүртгэлтэй 1606 харилцагч байгаагаа байгаа. Тус платформ дээр смарт төхөөрөмж, жолоочийн хариуцлага, эрүүл мэнд, гэнэтийн ослын зэрэг нийт 5 хэлбэрийн 15 төрлийн даатгалын үйлчилгээг 315 даатгуулагчид хүргэсэн ийм үр дүн үр дүнтэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны нэг гол үйл ажиллагаа бол энэ зах зээлийн судалгаа шинжилгээ дээр суурилсан, судалгаанд суурилсан бодлого шийдвэрийг гаргахаар ингэж ажилладаг ийм байгууллага.../үг тасрав/

Ц.Цэрэнпунцаг: Танилцуулга яаж байна, аль хаанаа яваа юм бэ?

Н.Хүдэрчулуун: Дуусаж байна. Статистик мэдээллүүдийг бол тогтмол хүргэж ажиллаж байгаа. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо болон гишүүдэд 7 хоног болгон, сар, улирал, жилээр статистик мэдээллүүдийг гаргаж ажилладаг. Мөн Хорооноос олон нийтэд хүргэх чиглэлээр цахим болон хэвлэмэл байдлаар салбарын статистик мэдээллүүдийг болбол тогтмол хүргэж ажилладаг байгаа гэдгийг бас хэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор энэ олон нийтийн санхүүгийн боловсролыг олон нийтэд хүргэх, энийг зохион байгуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо зохион байгуулдаг болсон. Энд хүүхэд залуучуудад чиглэсэн арга хэмжээ, орон нутгийн иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд салбарын оролцоог хангах чиглэлээр бол Санхүүгийн зохицуулах хороо бүх аймгууд болон нийт дүүргүүдийн хэмжээнд тусгайлсан арга хэмжээнүүдийг бас авч хэрэгжүүлдэг гэдгийг бас хэлье.

Санхүүгийн зохицуулах хороо олон улсын энэ хамтын ажиллагааг бас идэвхтэй, үр дүнтэй байдлаар ажиллаж байгаа. Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг, Дэлхийн банк, Японы санхүүгийн үйлчилгээний агентлаг, Бүгд Найрамдах Солонгос улсын Хадгаламжийн даатгалын корпорац, Казахстан улсын Астанагийн санхүүгийн үйлчилгээний байгууллага, Солонгосын Санхүүгийн үйлчилгээний хороо, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудтай нягт хамтын ажиллагаагаа хэрэгжүүлээд үр дүнтэй ажиллаж байгаа гэдгийг бас энд хэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны хуулиар бас олгогддог нэг чухал үйл ажиллагаа бол энэ компанийн засаглалын асуудал байдаг. Компанийн засаглалын кодексыг шинэчлэн баталснаар нээлттэй хувьцаат компаниудаас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ үзэгдэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалт, менежментийн компаниудыг дагаж мөрдөх үүргийг хүлээлгэсэн. Биелүүл эсхүл тайлбарла үнэлгээний аргачлалын дагуу 2023 онд нийт 124 тусгай зөвшөөрөлтэй этгээдэд кодексын хэрэгжилтийг давтан үнэлсэн. Уг давтан хянан баталгаажуулалтын дундаж үнэлгээгээр 84,9 хувь буюу 26,4 хувиар дээшилсэн гэсэн ийм үр дүн гарч

байна. Мөн Хөрөнгийн биржид бүртгэлтэй 104 хувьцаат компанийн кодексын хэрэгжилтийн үнэлгээ оны эцэст 15,2 хувийн хувиар өссөн гэсэн ийм үр дүнтэй байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр хийсэн ажлаас товчхон дурдъя. Санхүүгийн зохицуулах хорооноос энэ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 23-аас 30 оны энэ төлөвлөгөөг баталсан байж байгаа. Зохицуулалтад тусгаснаар Санхүүгийн зохицуулах хороо 2023 оны 142 дугаар тогтоолоороо тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын нэмэлт, өөрчлөлтийг батлаад ажиллаж байна.

Хорооны үндсэн бас нэг үйл ажиллагаа бол энэ хяналт шалгалт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт байдаг. Хорооны зохицуулалттай этгээд энэ хамрах хүрээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хороонд ирдэг өргөдөл гомдлын тоо хэмжээ бол их нэмэгдэж байгаа. 2022 онтой харьцуулахад 98 хувь өсөж 1187 хүрч цахимаар 419, албан бичгээр 768 ийм өргөдөл гомдол ирсэн байна. Хяналт шалгалтын нэг байцаагчид бас 70-аас 80 зохицуулалттай байгууллагуудыг зайны хяналт шалгалт хийгээд ингээд ажиллаж байгаа гэдгийг бас энд дурдъя.

Ингээд эцэст нь 2024 оны нийт гол зорьж ажиллаж байгаа бас ажлын зорилтуудаас бас тодорхой асуудлуудыг танилцуулъя. Нийт санхүүгийн зохицуулалттай энэ салбаруудын эрх зүйн шинэчлэлүүдийг үргэлжлүүлнэ гэсэн ийм зорилттой ажиллаж байна. Мөн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр бас тодорхой арга хэмжээнүүдийг авахаар төлөвлөөд ажиллаж байна. Мөн тогтвортой ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжих, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих гэсэн ийм үйл

ажиллагааны хүрээнд 24 оны зорилт, арга хэмжээгээ төлөвлөөд ажиллаж байгаа гэдгийгээ бас дурдъя. Ингээд анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Танилцуулгатай холбоотой гишүүд, уучлаарай, би өмнө нь энэ ажлын хэсэг танилцуулаадахъя. Ажлын хэсэг Нанжидын Хүдэрчулуун, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, Жамбаажамц санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Оюунчимэг тус хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга, Алтантуул тус хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга, Долгорсүрэн тус хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батболд тус хорооны Даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Энхтуяа Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, яасан олон орлон гүйцэтгэгчтэй юм бэ. Авир тус хорооны Компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга нар байхгүй байна уу? Болдмягмар тус хорооноос Банк, санхүүгийн санхүүгийн байгууллагын газрын ахлах зөвлөх, Нинжин тус хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх, Лхагвасүрэн тус хорооны Зах зээлийн хөгжлийн газрын референт. Гишүүд асуулт болон саналтай гишүүд нэрсээ өгнө үү. Ундрам гишүүнээр тасаллаа. Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Ундрам гишүүн асуултаа асууя. Саналаа хэлье.

Ч.Ундрам: Би энэ өнгөрсөн хугацаанд малчдын болон тариаланчдын хэлэлцүүлэг дээр яригдсан нэг хэдэн зүйлийг асуучихмаар байна. 1 дүгээрт энэ малчид банкнаас зээл авахдаа даатгуулдаг, заавал тийм байх ёстой байдаг. Тэгээд сая зуд болоод нэлээн малын хорогдол гарлаа. Энэ дээр одоо энэ даатгалын компаниудаас нь хэр хэмжээний нөхөн олговор олгогдсон бэ? Яг ер нь үндсэн одоо нөхөн олговор олгох нөхцөл нь яг ямар, хамгийн гол, гол

нөхцөлүүд нь ямар байдаг юм бэ гэдэг нэг асуулт байна.

2 дугаарт энэ малчдын хоршоо бас асуудал ярьж байна л даа. Одоо ноосоо самнаж угаагаад бүүр одоо Hermes, Chanel гээд компаниуд зардаг болчихсон тийм хоршоод бас байдаг юм байна. Тэгээд экспорт хийх гэхээр заавал энэ хөдөө аж ахуйн гаралтай биржээр ингээж арилжсан байх ёстой гээд. Бирж нь худалдан авагчийг нь олж өгөөгүй, өөрсдөө худалдан авагчаа олчихоод тэгээд одоо хууль журмын дагуу заавал бүртгүүлэх ёстой. Ингээд брокер, дилерийн газар очоод бүртгүүлэхээр хураамж гээд ямар ч ажил хийгээгүй, зүгээр нэг бүртгэл хийгээд л нөгөө ашгаас нь ингээд хураамж авдаг. Тэгээд энэ асуудал бол шударга биш байна. Бид нарын хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд худалдан авагч биржээр бол дамжиж олж өгөх ёстой болохоос биш бид нарын аль хэдийн олчихсон байгаа худалдан авагчийн дундаас нь зүгээр хууль, дүрмээрээ ингээд хураамж аваад байдаг асуудал байж болохгүй гэдэг ийм юм ярьж байгаа юм. Тэгэхээр энэ дээр яг ямар зохицуулалт байгаа юм гэдэг ийм асуулт байна.

Тариаланчид бас одоо газар тариалангийн холбогдолтой энэ төрөөс хөнгөлөлттэй зээл авах, хөдөө аж ахуйн яамны төсөл, хөтөлбөрт ороход бас заавал даатгалд хамрагдах ёстой. Эргээд ургацаа алдахаар ямар ч нөхөн төлбөр байхгүй. Тэгэхээр энэ даатгалын компани чинь зүгээр л нэг тэр журмын дагуу даатгал, даатгалын шимтгэлээ аваад л, тэгээд л алга болдог ийм асуудал яриад байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар одоо гарц гаргалгаа байдаг юм бэ? Ямар дүрэм журам байдаг юм?

Эцэст нь энэ хувьцаат компаниудын засаглалын асуудал бас нэлээн их ард иргэд ярьж байна. Тэгээд янз бүрийн цэнхэр, ягаан тасалбараар бас нэг хувьцаатай болчихсон хүмүүс ч тэр, сүүлийн үед Хөрөнгийн биржээр тэр дээр үеийн компаниудыг бас

арилжаа хийгээд нэг хувьцаатай болчихсон хүмүүс ч ярьж байна, сүүлийн үеийн компаниудын бас хувьцааг худалдаж авсан хүмүүс ч ярьж байна. Энэ санхүүгийн тайлангийн ил тод байдал гэж юм байхгүй. Тэгээд нөгөө компани нь өөрөө өөрийнхөө хамаарал бүхий гүйцэтгэх захирлын ч юм уу хамаарал бүхий компанид ингээд бараагаа ямар ч одоо ашиггүйгээр зарчихдаг. Тэгээд яг нөгөө цаад компани нь ашиг хийгээд байдаг ийм асуудал байна. Тэгэхээр энэ засаглалын асуудал хэрвээ ингээд зөв болохгүй бол хөрөнгийн бирж хэзээ ч хөгжихгүй. Яах вэ энэ нэг уул уурхайн бүтээгдэхүүний арилжаан дээр бол жсоохон идэвхтэй яваад байна. Тэрнээс бусад юман дээр бол ийм засаглалтай нөхцөлд хэзээ ч хөгжихгүй. Яг одоо дахиад IPO компани хийх юм бол хэн итгэж тэнд одоо хувьцааг нь худалдаж авч оролцох юм бэ энэ арилжаанд гэдэг ийм асуудал ярьж байна. Тэгэхээр одоо хүмүүс чинь нэг бол компани байгуулна, нэг бол энэ хувьцаа хөрөнгийн биржийн арилжаанд оролцоно, эсвэл тэгээд байгаа мөнгөө банканд л хадгалуулна ийм л сонголт байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр одоо ямар арга хэмжээ авч байгаа вэ гэсэн ийм 4 асуулт байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг хэдэн номер хариулах юм. Ажлын хэсгийн нэг номер Жамбаажамц хариулъя.

Т.Жамбаажамц: Ундрам гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Жамбаажамц байна. 4 асуулт асуулаа. 1 дүгээрт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг Монгол Улс баталсан 2010 онд баталснаа санаж байна. Энэ хуулийн дагуу хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд буюу одоо ноос, ноолуур, рапс зэрэг энэ хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн эд бол одоо хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдаж, тэгээд экспортод ер нь бол энэ саяын миний нэр дурддаг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүд бол

хөдөө аж ахуйн биржээр зөвхөн арилжаалагдах ийм хууль бол Монгол Улсад одоо үйлчилж байгаа. Энэ хуулийн дагуу угаасан болон самнасан ноолуур зэрэг энэ бүтээгдэхүүнүүд бол экспортод гарч байгаа энэ бүтээгдэхүүнүүд заавал Монгол Улсын 100 хувийн төрийн өмчтэй Хөдөө аж ахуйн биржээр бол арилжаалагдаж арилжаалагдсаны дараа гаалийн бүрдүүлэлт хийгээд ингээд гарах ийм бол орчин үйлчилж байгаа.

Зохицуулах зөвлөлтэй зохицуулах зөвлөл нь бол хөдөө, Хунс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бол дэргэд бол байдаг. Энэ хүрээндээ бол Удирдах зөвлөл нь бол хяналт тавиад ажилладаг. Засгийн газраас яг энэ хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн биржээр арилжаалагдах бараа, бүтээгдэхүүний нэр төрлийг бол тогтоож өгөөд тухай бүр ингээд л явдаг. Сая ковидын үеийн зохицуулалтаар бол энэ биржийн арилжааны шимтгэлийг бол тодорхой хугацаанд бол юу яасан тэглэсэн байж байгаа, одоо өөрөөр хэлбэл ямар нэгэн шимтгэлгүйгээр биржийн арилжаа бол явж байгаа тодорхой хугацаанд. Энэ бол одоо яг Санхүүгийн зохицуулах хорооны харьяалах гэхээсээ илүү энэ бол яг Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа ийм харилцаа байгаа юм 1 дэх асуулт.

2 дахь асуулт нь бол Монгол Улсад энэ малын индексжүүлсэн даатгалын харилцаа бол явдаг. Үүний дагуу Үндэсний давхар даатгал гэж ийм төрийн өмчтэй компани бий. Өнөөдрийн байдлаар бол энэ зудын эрсдэл, малын эрсдэлийг бол энэ аймгуудыг аймгууд дээр тодорхой хэмжээний малчдын энэ малыг бол энэ малын индексжүүлсэн даатгалын хүрээнд Үндэсний давхар даатгал компани бол зохион байгуулаад дотоодын даатгалын компаниуд бол ингээд даатгаад явдаг. Зүгээр энэ дээр бол яах вэ Засгийн газар сая 2023 оны 12 сард, сарын 27-ны өдрийн 473 дугаар

тогтоолоор даатгалын босго үзүүлэлтийг бол аймаг орон нутгаар нь бол ялгаатай байдлаар тогтоосон. 1 дүгээр босго үзүүлэлтүүд бол 5-аас 6 хувьтай. 2 дугаар босго үзүүлэлт бол 25-аас 30 хувьтай иймэрхүү хэлбэрээр бол шинэчлээд тогтоочихсон. Энэ юуны хүрээнд бол одоо энэ хагас жилийн мал тооллогын үндсэн тооллогын дүн гарсны дараагаар ерөнхийдөө энэ тодорхой даатгалын тохиолдлууд дээр нөхөн олговор олгогдоод бол явна. Энэ дээр бол Монгол Улсын үндэсний давхар даатгал гээд төрийн өмчтэй 100 хувийн ийм компани, тэгээд илүү гарсныг нь бол олон улсын давхар даатгалын компани бол хариуцаад ингээд явдаг.

Даатгалын компаниуд дээр бол хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн, бизнес эрхлэгчдийн даатгалыг бол даатгадаг. Тэр хүрээндээ бол 2 талын одоо сайн дурын хэлбэрээр бол даатгаад явдаг ийм бол хэлбэрүүд бий. Хэрвээ одоо тодорхой даатгалын гэрээгээр зохицуулагдаад, даатгалын тохиолдол үүссэн тохиолдолд бол даатгагч, даатгуулагч нар бол хоорондоо даатгалын тохиолдлынхоо дагуу тухайн тохиолдол дээр нь нөхөн төлбөрөө олгох эсэх асуудлаар бол шийдэгдээд явдаг байгаа.

Эцэст нь Ундрэм гишүүний тэр сүүлийн асуулт бол аягүй чухал асуулт асуулаа гэж бол би ойлголоо. Энэ хувьцаат компаниудын засаглалын асуудал. 1990 онд бол томоохон хэмжээний хувьчлал Монгол Улсад явагдсан. Тухайн үеийн бол 475 улсын үйлдвэрийн газрыг хувьцаат компани өөрөөр хэлбэл.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээж хариулах уу? Гүйцээж 1 минутад дахиад гүйцээгээд хариулчихъя. Жамбаажамц 1 номер.

Т.Жамбаажамц: Хөрөнгийн биржээр дамжуулж олон нийтийн компани болгосон. Энэ бол өөрөөр хэлбэл тэр их хувьчлал буюу цэнхэр

тасалбараар энэ 475 хувьцаат компанийг бол хувьчилсан. Тухайн үедээ бол иргэд энэ компаниудын хувьцаа одоо брокерын нүүсээрээ дамжуулаад хувьцаа эзэмшүүлсэн. Түүнээс хойш бол арван, 33, 34 жилийн хугацаа өнгөрсөн байна. Энэ хугацаанд бол тодорхой энэ компаниудын хувьцаа эзэмших эзэмшлийн процесс бол нэлээдгүй бас төвлөрөл нэлээн өндөр явагдсан. Нөгөө талаас бол одоо энэ үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд энэ хүрээнд бас ажиллаж явж байгаа. Санхүүгийн зохицуулах хорооноос манай түрүүн тайланд дурдсанаар бол энэ нээлттэй ил тод байх чиглэл дээр ялангуяа энэ компанийн засаглал нээлттэй, ил тод тунгалаг байх чиглэл дээр бол нэлээдгүй анхаарч ажиллаж байгаа. Сүүлийн 2 жилийн хугацаанд Монгол Улсын компанийн засаглалын кодексыг бол шинэчлээд энэ хүрээнд бол хагас жил, жилийн эцсээр өөрийн үнэлгээний системд шилжүүлээд явж байгаа. Тодорхой хэмжээний бас.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ундрэм гишүүн асуулт асууж, хариултаа авлаа. Ингээд Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Энэ Санхүүгийн зохицуулах хорооны тайлангаас 2 зүйл асууя. Эхнийх нь энэ тайлан дээр байгаагаар 1,6 сая иргэн аппликэйшний зээлтэй гэсэн байна л даа. Энэ чинь өөрөө нийт насанд хүрсэн иргэдийн бараг 70-аад хувь, албан ёсны хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн чинь бараг 100 хувиас давсан тоо болчихоод байна л даа. Тэгэхээр энэ өөрөө ер нь тийм эрүүл үзэгдэл үү? Энэ дээр ер нь ямар дүгнэлттэй байдаг юм? Олон улс, бусад харьцуулах үзүүлэлтүүд харахлаар энэ ямар нөхцөл байдалтай байдаг юм бол 1 дүгээрт нь.

2 дугаарт нь яг одоо манай хөрөнгийн зах зээлийн хэдэн хувийг төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, төрийн өмчит болоод төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд

хөрөнгийн зах зээлийн хэдэн хувийг бүрдүүлж байгаа юм бэ? Яг энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг чинь дагаад л нөгөө нэг авлигын асуудал, есөн жорын асуудлууд чинь энд л авлига, хулгайн асуудлууд чинь энд л яригдаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэтэй холбоотой та нар тэр санхүүгийн ил тод байдал, засаглалын талаар хийсэн ямарваа нэгэн үнэлгээ, үнэлэлт дүгнэлт шалгалтууд, эндээс гарч байсан дүгнэлтүүд ер нь юу байдаг юм өнгөрсөн хугацаанд? Энэ 2-т тодруулгаа өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: 2 тодорхой асуулт асуулаа. Ажлын хэсгийн 1 номер Жамбаажамц хариулъя.

Т.Жамбаажамц: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ажлын албаны дарга Жамбаажамц байна. Өнөөдрийн байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр төрийн 100 хувийн өмчтэй, төрийн өмчийн оролцоотой гэж ингээд төрийн өмчийн компаниудыг бол 2 ангилж байгаа. Нийтдээ 15 компани байна. Төрийн өмчийн оролцоотой, төрийн өмчийн өмчит. Үүнээс 4 компани бол төрийн, одоо 100 хувийн өмчтэй 4 компани байна Хөрөнгийн биржийн бүртгэл дээр. Төрийн өмчийн оролцоотой 11 хувьцаат компани байгаа юм. Төрийн өмчийн оролцоотой. Тухайлбал энэ төрийн өмчийн оролцоотой гэдэг нь төр бол тодорхой хувиар эзэмшдэг, тухайлбал Багануур хувьцаат компани гээд тэгэхээр 75 хувийг нь төр эзэмшдэг, 25 хувь нь бол олон нийт дээр чөлөөтэй арилжаалагддаг Баян тээг байгаа. Энд бол төрийн болон орон нутгийн өмчийн компаниудыг бол хамтад нь оруулчихсан байна. Төр 70 хувийг нь эзэмшдэг, 30 хувь нь олон нийтийн хөрөнгийн бирж дээр бол арилжаалагддаг. Могойн гол гээд Хөвсгөлийн компани байна 51 хувийг нь төр, орон нутаг эзэмшдэг, 49 хувийг нь иргэд эзэмшдэг, олон нийт эзэмшдэг зэрэг ийм компаниуд байгаа юм.

Цогтгэрэл гишүүний асуултад бас тодорхой яг ийм мэдээлэл нэмж

өгөхөд энэ компаниуд дээр Санхүүгийн зохицуулах хороо бол яг өнгөрсөн жил 2023 оны 12 сард нийтдээ 13 төрийн 100 хувийн өмчтэй компаниудыг бол бүртгэлээс хассан. Өөрөөр хэлбэл өмнө нь одоо ганцхан хувьцаа эзэмшигчтэй, төрийн 100 хувийн хувьцаа эзэмшигчтэй. Тэгээд энэ хувьцаа нь бол хөрөнгийн биржээр огт арилжаалагддаггүй ийм компаниуд байсан. Энийг бол Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол гаргаад 13 ийм компаниудыг бол нээлттэй хувьцаат компаниас хаалттай хувьцаат компанийн хэлбэр лүү нь шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл хөрөнгийн биржийн бүртгэлээс хасаад, тэгэхдээ тэр компани нь бол хувьцаат компанийн хаалттай хэлбэрээр нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр бүртгэл, хувьцаа нь бүртгэгдээд ингээд явж байгаа.

Ер нь бол ганц хувьцаа эзэмшигчтэй, тэр нь хувьцаа нь арилжаалагддаггүй төрийн өмчит Хөрөнгийн бирж дээр public компани байх нь бол өөрөө олон улсынхаа жишигт нийцэхгүй гэж үзэж байгаа учраас одоо эндээс бол 4 компани бол үлдсэн байгаа. Энэ 4 компанийг нь Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах ажил бол яг одоо явж байгаа 100 хувийн төрийн өмчтэй компани. Компани нь өөрөө хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээ гаргаад, хэлбэрээ өөрснөө Компанийнхаа хуульд заасны дагуу сонгоод, тэгээд хороонд ирүүлээд хасдаг ийм процесстой. Яг энэ процесс бол хэрэгжээд явж байна.

Финтекийн зээлтэй холбоотой мэдээлэл дээр ерөнхийдөө Цогтгэрэл гишүүний асуултад нийтдээ банк бус санхүүгийн салбарт сая 1,6 сая орчим зээлдэгч байгаа юм. Энэний 1318717 нь одоо финтекийн буюу одоо бид нарын ярьдаг нөгөө аппликэйшн дээр суурилсан ийм зээлийн үйл ажиллагаа бол явдаг. Энэ нь бол нийт зээлдэгчийн бол 82,4 хувийг эзэлж байгаа боловч дундаж зээлийн хэмжээ бол 575,2 сая, мянган төгрөгийн ийм зээлийн дундажтай ийм

бол байдаг. Монгол Улсад өнөөдөр 500 гаруй ийм банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа бол явуулж байгаа. Үүнээс яг энэ аппликэйшин дээр суурилж зээлийн үйл ажиллагаа явуулж байгаа 55 нэр бүхий банк санхүүгийн байгууллага байгаа. Эдгээрийн бол 1,3 сая орчим нь саяын миний дурддаг ийм тоонууд дээр бол финтекийн зээл бол явдаг. Ерөнхийдөө бол одоо технологид суурилсан, ялангуяа энэ санхүүгийн зах зээлийг технологид суурилсан энэ хэлбэр лүү үйлчилгээ бол маш хурдтай явж байгаа.

Ерөнхийдөө дэлхий нийт энэ цахим шилжилт, цахимжилт, санхүүгийн хүртээмж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нэмээд бол байгаа газраасаа цаг хугацаа, орон зайнаас үл хамаараад санхүүгийн үйлчилгээг авах тийм хурдан шуурхай байдлыг бол ихээхэн хангаж өгөхөөр одоо дэлхийн санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллага болон мэргэжлийн институтууд бол энэ дээр онцгой анхаарч ажиллаж байгаа. Энэ хүрээний нэг зээлийн одоо нэг финтек дээр суурилсан нэг төрлийн л үйлчилгээ бол энэ зээлийн үйлчилгээ байгаа юм. Үүнээс гадна тэр брокерууд.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Харин сая миний асуусан асуултыг чи надад эргүүлээд л яг тэр чигээр нь асуултыг нь л хэлээд өгчих юм яг давтаад. Би төрийн өмчит болоод төрийн өмчийн оролцоотой гэж энэ аж ахуйн нөгөө хувьцаат компанийн хэлбэрээр явуулж, аж ахуйн нэгжүүд нийт хөрөнгийн зах зээл дээрээ ямар хувь хэмжээ агуулж байгаа юм бэ? Тэгээд эд энэ компаниудын засаглалд танайх ямар үнэлгээ хийсэн, мэдээллийн ил тод байдал нь хэрхэн хангагдаж байгаа юм, тэр комплайнс тогтолцооны талаар ямар үнэлэлт дүгнэлттэй байдаг юм бэ гэдэг л асуулт асуусан л даа, тэгэхээр 1 дүгээрт нь.

2 дугаарт нь тэр саяын тэр финтек салбарын дахиад энэ одоо болж байгаа яг 1,6 сая, 1,4 сая орчим иргэн энэ чинь болбол тоо хэмжээ нь бас их өндөр байгаад байна л даа. Зүгээр энэ нь өөрөө ингээд явж байгаа процессыг та нар Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ингээд эрүүл үзэгдэл, улам цаашаа ингээд хөгжүүлэх ёстой гэж одоо үзэж байна уу? Энэ дээр наад хувь процесс хэмжээ чинь процент чинь бас хэтэрхий их өндөр, зүгээр ингээд 100 хувь л болчихоод байна л даа.

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээж хариулья. Ажлын 1 номер.

Т.Жамбаажамц: Төрийн 100 хувийн өмчтэй 4 компани Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байгаа. Өнөөдөр Хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ тооцдог аргачлалаар бол энэ төрийн 100 хувийн өмчтэй компанийн хувьцаа нь арилжаалагддаггүй учраас зах зээлийн үнэлгээнд оруулж огт тооцдоггүй юм. Тэгэхээр зах зээлийн үнэлгээнд энэ төрийн 100 хувийн өмчтэй компаниудын үнэлгээ бол огт орж тооцогддоггүй гэсэн үг. Зах зээлийн үнэлгээ дээр бол тэгж нөлөөлдөггүй гэсэн үг. Яагаад гэхээр одоо энэ хувьцаа нь огт арилжаалагддаггүй 100 хувийн, одоо төвлөрсөн хадгаламжийн бүртгэл дээр 100 хувийн төр хувьцааг нь эзэмшдэг, хэзээ ч хувьцаа нь арилжаалагдаж байгаагүй ийм компани учраас үнэлгээнд тооцдоггүй.

Финтек дээр бол ерөнхийдөө яг гишүүний Цогтгэрэл гишүүний асуулт бол илүү нөгөө иргэдийг илүү зээлийн дарамтад оруулаад байна, маш их хэмжээний одоо зээл энд олгоод байна гэдэг агуулгаар илүү асуугаад байх шиг байна. Бид нар бол Санхүүгийн зохицуулах хороо энэ дээр үнэхээр онцгой анхаарч байгаа. Ялангуяа иргэдийг, энэ бол бас нэг онцлог нь барьцаагүй ийм онцлогтой зээл шүү дээ, байгаа газраасаа авдаг. Тэгээд хороо бол энэ дээр нөгөө.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Дахиад ажлын хэсгийн 2 номер байна уу, 2, саяын хариулт дээр гүйцээгээд хариулчих, 1 минут.

Н.Хүдэрчулуун: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод энэ санхүүгийн салбарыг илүү технологид суурилсан смарт санхүүгийн системийг бий болгоно гэсэн ийм зорилтыг дэвшүүлсэн байж байгаа. Энэ хүрээндээ бас Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөөг бас баталсан байдаг. Энд болбол технологид суурилсан байдлаар энэ санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ гэсэн үндсэн чигийг чиглэлийг бариад ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл, олон улсын энэ санхүүгийн салбарт гарч байгаа өөрчлөлтийн нэг гол өөрчлөлт болбол энэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ маш ихээр нэвтэрч байгаа. Энд бас тодорхой, таны бас энэ бодож байгаа тэр эрсдэлүүд бас байгаа. Өөрөөр хэлбэл, иргэдийг зээлийн дарамтад, өрийн дарамтад орох ийм эрсдэлүүд байдаг. Энэ төрлийн зохицуулалтуудыг нь бас Санхүүгийн зохицуулах хороо хийгээд явж байгаа. Өөрөөр хэлбэл, тухайн иргэний орлого, орлоготой нь өр, орлогын харьцаагаар нь бас тодорхой хязгаарлалтуудыг тавиад, тэр нь яг энэ аппликэйшин дээр нь бол.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мөн үг хэлж дууслаа. Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дууслаа. Та бүхэн гарч болно. Ажлын хэсгийнхэн гарч болно.

14.39 цаг

Гурав. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, нэн яаралтай/

Дараагийн асуудалдаа оръё. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр танилцуулна. Баттөмөр гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилъё. Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг өргөн мэдүүлсэн. 2024 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн Эдийн засгийн байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг хийж, анхны хэлэлцүүлэгт бэлдэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, даргын захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөр ахлуулж, улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, Доржханд, Оюунчимэг, Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсэг ажлын дэд хэсгийг байгуулсан. Энд бол 17 хүний бүрэлдэхүүнтэй холбогдох яамнууд, Монголбанк, гааль, татварын газрууд болон мэргэжлийн байгууллагуудыг одоо оролцуулсан ажлын дэд хэсгийг байгуулсан. Ажлын дэд хэсэг бол үндсэндээ 7 хоног хэртэй ажилласан. Зарчмын зөрүүтэй саналын томъёолуудыг бэлтгэж ажлын хэсэгт одоо ирүүлсэн.

Ажлын хэсэг 2024 оны 16 оны, 2024 оны 4 сарын 16-ны өдөр хуралдан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлтэй

холбогдуулан мэдүүлсэн 35 зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэсэн. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол нь хуулийн төслийн зарим хэсэг, заалтыг бусад хуулийн хууль тогтоомжтой нийцүүлэх, нэр томьёог тодорхой болгох, өргөн мэдүүлсэн нь Ирээдүйн өв сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хоорондын нийцлийг хангах, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулийн этгээдийн гаргасан хувьцааны 20-иос дээшгүй хувийг аливаа этгээд дангаар болон харилцан хамаарал бүхий этгээд хамт эзэмшихийг хориглохоор тусгасныг 34 хувь болгон өөрчлөх, түүнчлэн улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд төрийн эзэмшлийн хувь хэмжээтэй холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулах зэрэг хүрээг одоо хамарлаа.

Хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлд Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, 2024 оны хаврын ээлжит чуулганд багтаан Улсын Их Хуралд танилцуулах, Монгол Улсын иргэн бүрд 2024 оны 2 дугаар улиралд багтааж хуримтлалын нэрийн данс үүсгэх, үүнд Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан хуримтлалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Их Хуралд өргөн мэдүүлэх, мэдүүлэхийг

Засгийн газарт үүрэг болгосон заалтыг мөн тусгаж өглөө.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон холбогдох төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүнд баярлалаа. Ингээд ажлын хэсгийг та бүхэндээ танилцуулъя. Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Мэндбаяр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батжаргал нийгмийн хамгаалал, хөдөлмөр, Хөдөлмөрийн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батсайхан Монголбанкны Төлбөр тооцооны газрын Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал, Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Агиймаа Засгийн газрын Хэрэг эрхлэх эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн, Баярмандал Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Батмагнай Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга, Давааням Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор, Гэрлээ Эрдэнэс Монгол ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер. Ажлын хэсгийнхнээс, танилцуулгаас ажлын хэсгийнхний танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Батлут гишүүнээр тасаллаа. Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Энэ Баялгийн сангийн тухай хуулийг зарчмын хувьд бол

дэмжиж байгаа. Тэгээд хэд хэдэн ойлгомжгүй зүйлүүд надад байгаад байна л даа. Тийм учраас ажлын хэсгийн хэсгээс асуух, асуумаар байна. Энэ одоо ирээдүй өв санд тодорхой мөнгө хуримтлагдаад, энийг хөрөнгө оруулах замаар өнөөгийн үнэ цэнийг өсгөнө, арвижуулна гээд тэгж байна. Тэгэхээр энэ дээр яг одоо нэг менежментийн баг гарч ажиллаж таарна. Тэгээд тодорхой хөрөнгө оруулалтуудын шийдвэрүүдийг гаргана. Эндээс тухайн менежментийн баг алдагдал гаргаад, нөгөө бид нарын ирээдүй үедээ өвлүүлэх гээд байгаа мөнгийг чинь алдчихвал ч юм уу, хэсэгчлэн алдчих юм бол ямар хариуцлага тооцох юм бэ? Энэ менежмент хийх багийг нь хэн, яаж, ямар зарчмаар сонгож ажиллуулах юм бэ гэдэг ийм нэг асуулт байна.

Хуримтлалын сан нь болохоор иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууц гээд ийм хэрэгцээг хангахад зарцуулагдана. Тэгээд төрийн санд одоо байршина, хүн болгоны нэр дээр нэрийн данс нээгдэнэ гэж байна. Тэгэхээр жишээлбэл иргэн Дорж хүүхдийнхээ боловсролд энийг зарцуулахын тулд яг ямар журмаар явах вэ? Нөгөө бид нар чинь өнгөрсөн хугацаанд ингээд л энэ сангууд чинь илүү эрх мэдэлтэй, мэдээлэлд ойр хүмүүст нь илүү зарцуулагдаад, мэдээж хөрөнгө санхүү чинь хэмжээ хязгаартай, хүний хүсэл хязгааргүй. Тэгэхээр яг ийм зөв зарчмын дагуу яг байгаа оносон энэ иргэдийн амьжиргаа, боловсрол, орон сууц, эрүүл мэндэд яг ямар журмын дагуу шударгаар хуваарилагдаж очих юм бэ гэдэг ийм асуулт байна.

Хөгжлийн сангийн мөнгө нь болохоор том, том төсөл хөтөлбөрт зориулагдах юм байна. Тэгэхээр тэр шийдвэрийг хэн гаргах юм, Улсын Их хурал гаргах юм уу, эсвэл хаана нэгэн газар бас 2, 3 дарга сууж байгаад шийдчих юм уу? Энэ л одоо бид нар энийг л зөв хийхгүй бол зөндөө ийм сан байгуулаад л зарцуулалт нь буруу явчихвал энэ хууль чинь ямар ч ач

холбогдолгүй болчихно. Тэгэхээр ийм асуултад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хариулъя.

Б.Баттөмөр: Ирээдүй өв сангийн хуулийг 2016 онд баталсан. Энэ хууль бол үр дүнгээ өгөөд өнөөдөр 3,3 их наяд төгрөгийн хуримтлалтай. Монгол Улс анх удаа энэ ирээдүй өв сандаа 1 тэрбум долларын хуримтлал бий болгож чадсан байгаа. Ирээдүй өв сангийн хөрөнгийг 2030 он хүртэл хэрэглэхгүй хуримтлал болно. Энд үнэ цэнийг нь өсгөх гэдэг асуудал байгаа. Энийг бол Монголбанктай хамтраад тэр гаднын Засгийн газруудын хөгжилтэй орнуудын Засгийн газрын бонд, хувьцааг худалдаж авах өндөр үр ашигтай, өөрөөр хэлбэл нөгөө ЗА гэж ярьж байгаа шүү дээ тийм ээ, нэмэх ЗА, энийг худалдаж авах асуудлыг энд тавьж ирж байгаа юм. Энэ Ирээдүй өв сангийн хуульдаа бас заачихсан байгаа. Мандат гэж батлаад, тэр мандатад болбол яг сая миний хэлсэн шаардлагуудыг тавьчихсан байгаа. Тийм учраас энэ дээр болбол энэ дээр үнэ цэн алдах, барих ийм асуудал бол эрсдэл болбол би байхгүй гэж одоо үзэж байна.

Менежментийг нь хэн хийх вэ гэж. Менежментийн хувьд болбол юу гэхээр энэ ирээдүй өв сангийн менежмент бол эхний ээлжид дандаа хуримтлагдаж л явна. Энэ дээр бол өсгөх асуудал гарах юм болбол Монгол Улсын Засгийн газар, тэгээд Монголбанктай хамтраад энийг тэр өсгөх асуудлуудыг нь тухайн, тухайн үед нь одоо шийдээд явах юм гэж. Хөгжлийн санг энэ хөтөлбөрийг хэн гаргах вэ гэж. Энийг Засгийн газар гаргана. Засгийн газрын гаргасан саналыг Улсын Их Хурал батална. Одоо юу гэдэг юм Асгатын мөнгөний ордод хөрөнгө оруулалт хийнэ, Эгийн голын усан цахилгаан станцад хөрөнгө оруулалт хийнэ гэдэг ч юм уу энэ шийдвэрийг болбол Улсын Их Хурал гаргана. Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг Засгийн газар хэрэгжүүлнэ. Энэ дээр ямар нэгэн одоо тийм эрсдэл

бол гарахгүй гэж ингэж үзэж байгаа. Тийм. Өөрөөр хэлбэл улс орны эдийн засагт ач холбогдолтой, цаашдын хөгжилд ач холбогдолтой энэ төсөл, арга хэмжээнүүдийг бол бид болбол Улсын Их Хурал бол Засгийн газрын гаргасан саналын дагуу гаргаад гүйцэтгэлийг нь болбол Засгийн газар, Улсын Их Хуралд тайлагнана. Энэ дээр болбол ямар нэгэн дураараа хүн хөрөнгө оруулалт хийх, тэр Хөгжлийн банк дээр гарсан тэр алдаанууд бол давтагдахгүй гэж үзэж байгаа. Хуримтлалын сангийн юмыг нь асуудлыг бол манай Наранцогт дарга, ажлын дэд хэсгийн ахлагч хариулчихъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер Наранцогт захирал хариулъя.

С.Наранцогт: Ундрам гишүүний асуултад тодруулж хариулъя. Хуримтлалын сан бол данс нь өөрөө Монголбанканд дээр байршина. Энэ нь бол нийтдээ нийт иргэдийн нэрийн дансны одоо нэгдсэн дүнгээрээ Монголбанк дээр байрлана гэсэн үг. Ер нь зарцуулалт бол бэлэн бусаар орон сууц, боловсрол, эрүүл мэндийн зориулалтаар гэдгээр яг энэ хуульд бол ингэж орж байгаа. Яг бэлэн бусаар ямар хөтөлбөрүүд санхүүгийн зах зээл дээр бий болох вэ, тэрэн дээр нь яаж одоо иргэдэд боломж олгох вэ, тэрийг бол ингээд журмаар, журмыг Засгийн газар батлахаар оруулж ирж байгаа. 2 журам гарна, 1 дүгээрт хөрөнгө оруулалтын бодлого тухайн нөгөө жилийн төсөвт төвлөрөх энэ санд төвлөрөх хөрөнгө үүнтэй уялдаад бас Монголбанктайгаа хамтарч явна. Энэ банкнууд санхүүгийн зах зээл дээр ямархуу бас энэ энийг дагасан жишээлбэл, орон сууц дээр ямархуу бүтээгдэхүүнүүд бий болох вэ гэдэг дээр тулгуурлаж тухайн жилд нь саналуудаа явуулна.

Яг нийт дүнгээрээ бол бид нар ийм, ийм хөтөлбөрүүд хэрэгжинэ, ийм хэмжээний зарцуулалт хийгдэнэ гэдэг нь мөн ялгаагүй Их Хурал дээр очиж батлагдах юм. Засгийн газар дээр

төсөвтөө нэгтгэж орж ирээд. Тийм учраас болбол иргэд өөрсдийнхөө дансанд ямархуу хэмжээний хуваарилалт хийгдсэн гэдгийг өөрийнхөө гар утасны аппликэйшн дээр харах боломжтой болно. Тэр нь, тэндээсээ бас нөгөө ямархуу боломжийн бүтээгдэхүүнүүд бий болж байна, тэрэнд өөрөө зарцуулалт хийх хүсэлтээ илгээх тийм боломжийг бас аппликэйшнээр бий болгож өгнө гэсэн ийм их төлөвлөгөөтэй байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Баялгийн сангийн тухай хуулийг хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Иргэд ирээдүй рүүгээ чиглэсэн сайн санаачилгыг одоо Засгийн газраас гаргаж ирж байна гэж харж байна. Тэгэхдээ энэ сайн санаачилга байгаа ч гэсэн сайн хууль бас гарах ёстой. Тэгж байж одоо бас энэ санаачилгын үр дүн, энэ байгалийн баялгийг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх энэ үндсэн зорилго, агуулгадаа нийцсэн нийцэж өгнө гэж харж байгаа. Тэгээд урьд нь манай Монгол Улсын түүхэнд чинь олон сангууд байгуулагдсан, тэгээд түүнтэй холбоотой зөндөө л асуудлууд яг одоо энэ өнгөрсөн 3, 4 жилийн хугацаанд нэлээн ил тод болж байх шиг байна шүү дээ. Тухайлах юм бол Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн асуудал, Хөгжлийн банкны асуудал гээд л. Тэгээд энэ асуудлуудыг ингээд хараад байхаар ямар түвшинд, ямар зохион байгуулалт хийгдэж, энэ буруу, нөгөө мэдээлэлд ойрхон байсан хүмүүс нь хулгай хийсэн ч гэдэг юм уу ийм асуудлууд гарсан бэ гэхээр удирдлагын түвшиний, шийдвэр гаргах түвшиний л хүмүүсийн оролцоо нэлээн байдаг, тийм л дүр зураг харагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ Сангийн тухай хууль дээр одоо бас тодорхой байх болов уу гэж харж байгаа. Шийдвэр гаргах түвшиний энэ хүмүүсийн хүмүүст

тавигдах шаардлага гэж ямар шаардлага байх вэ, энийг бүүр маш сайн тодорхой болгож өгөх хэрэгтэй байгаа. Тэгээд томилгоо, шалгуур нь ямар, хэрхэн байх юм, хэн томилох юм тэр хүмүүсийг, тэгээд дээрээс нь энэ сангийн ил тод байдлыг хэрхэн хангах юм бэ, шилэн байдлыг хэрхэн хэрхэн хангах юм бэ? Ингээж хийхгүй бол яг үндсэндээ бас нэг урьдын алдаанууд давтагдсан нөхцөл байдал бий болчих вий гэж бид ч гэсэн, нийгэм тэр чигтээ бас болгоомжилж байгаа юм. Тийм учраас гол одоо зонхилж байгаа асуудал юу вэ гэхээр ерөөсөө л энэ шийдвэр гаргах түвшний хүмүүст тавигдах шаардлага, тэднийг хэн томилох юм, ямар шалгуур үзүүлэлтүүдээр томилох юм, тэгээд энэ сангийн ил тод байдлыг хэрхэн хангах юм бэ гэдэг асуудал гол болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр надад нэг хариултууд өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт нь яах вэ янз янзын хэлбэрээр энэ хөрөнгө оруулалт хийх юм байна гэж харлаа сангаас. Тэгээд сая одоо манай Таван толгойгоос ингээд л хувь хишиг хүртээгээд л явсан л даа. 2 талтай байгаа энэ. Нэг талдаа ноогдол ашгаа авч байгаа нь сайн зүйл боловч нөгөө талдаа зах зээл дээр нэг баахан бэлэн мөнгө гаргаж ирээд тэгээд инфляц хөөрөгддөг. Нийгмийн нөгөө нэг сөрөг үзэгдлүүд, асуудлууд тухайн цаг мөчид ихэсдэг ийм нөхцөл байдалд хүрч байгаа юм, бий болгож байгаа юм. Жишээлбэл яг 4 сарын 4-ний өдөр ноогдол ашгаа авахад л нэг Улаанбаатар хотын хэмжээнд 144 хүн эрүүлжүүлэхэд хоносон. Гэр бүлийн хүрээний хүчирхийлэл 74 гарсан байх жишээтэй гээд л. Тэгээд энэ байдлаас бид нар цаашидаа яаж хэрхэн ангид байх юм бэ? Ер нь цаашидаа энэ сантай холбоотой эргээж одоо ард иргэд рүү харсан хуваарилалтуудаа хэрхэн хийх вэ гэдэг тал дээр өөр тодорхой зарчмын саналууд байгаа юу гэдэг тал дээр хариулт авъя. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хариулъя.

Б.Баттөмөр: Сайн хууль батлах ёстой гэж. Энэ Баялгийн сангийн тухай хууль анхдагч хууль. Тэгэхээр энэ манай Эрдэнэс Монгол компаниас одоо мэргэжлийн хүмүүсээр, эрдэмтдээр судалгаа хийлгэсэн юм байна лээ. Тэр судалгаагаар болбол юу гэхээр зэрэг ер нь бол энийг их цомхон, эхлэлийн шинж чанартай явж байгаа учраас цомхон хийх нь зүйтэй гэсэн ийм судалгааны дүн гарсан юм байна лээ. Ингээд үзээд бид нар болбол энд бол юу гэхээр Засгийн газраас оруулж ирсэн санал болбол зүйтэй гэж ажлын хэсэг үзсэн юм. Шийдвэр гаргах түвшний шаардлага гэж байгаа юм л даа. Шийдвэрийг бол Улсын Их Хурал гаргана, тийм ээ. Улсын Их Хурал гаргана. Улсын Их Хурлын гишүүд л хариуцлагатай байх ёстой. Засгийн газар Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг Пүрэвдоржоо, би уг хэлчихье. Үг хэлчихье.

Шийдвэр гаргах түвшний шаардлагыг бол яах вэ Засгийн газар болбол Улсын Их Хуралд саналаа оруулж ирнэ. Тэрийг нь Улсын Их Хурал батална. Улсын Их Хурлын шийдвэргүйгээр ямар ч одоо санхүүжилт хийгдэхгүй. Энэ 3 сан болбол Ирээдүйн өв сан нь болбол Монголбанкн дээр валютаар хадгалагдана. Нөгөө 2 сан нь Хөгжлийн сан, Хуримтлалын сан нь Монголбанкны банкн дээр байгаа Төрийн сан дээр одоо тэр мөнгө нь орж байгаа юм. Өнөөдөр болбол би түрүүн хэлсэн Ирээдүйн өв санд 3,3 их наяд төгрөг, энэ жил дахиад 1 их наяд төгрөг. Энэ Монгол Улс бол үндсэндээ нэг 1,3 орчим тэрбум долларын нөөцтэй болж байгаа юм. Хуримтлалын сан, Хөгжлийн сангууд нь энэ жил ингээд бүрдэнэ. Тэгэхээр зэрэг эндээс болбол бид юу гэж хүлээж байна гэхээр зэрэг 2030 он хүртэл бол тодорхой хэмжээний хуримтлал үүснэ. Манай Засгийн газраас бол 13 орчим их наяд төгрөгийн хуримтлал үүснэ гэж үзсэн. Бидний тооцож байгаагаар бол 18-аас 20 орчим их наяд төгрөгийн хуримтлал үүсгэх боломжтой гэж үзэж байгаа.

Нэгэнт шийдвэр гаргах түвшин нь Их Хурал байх учраас энийг захиран зарцуулдаг тийм аппарат одоо юу гэдэг юм тийм байгууллага бол байхгүй. Их Хурлын гаргасан шийдвэрийг Засгийн газар хэрэгжүүлээд л явна гэсэн үг. Ил тод байдлыг яаж хангах вэ гэж. Ил тод байдал болбол энэ баялгийн сантай холбогдож гарсан Улсын Их Хурлын шийдвэрийг 10 хоногийн дотор олон нийтэд мэдээлэх, Засгийн газрын гаргасан шийдвэрийг мөн 10 хоногийн дотор мэдээлнэ. Энэ нэгэнт Улсын Их Хурлаас санхүүжүүлэх хөгжлийн хөтөлбөр юм уу, энэ ард иргэдийн тэр нийгмийн асуудлыг шийдэхтэй холбогдсон арга хэмжээ болбол юу вэ гэхээр бүгд ил тод, шилэнд дансаар байна. Тийм учраас бид сая хэний Батлут гишүүний хэлж байгаа олон сан дээр их дутагдал гарсан. Энэ сан дээр болбол ямар нэгэн дутагдал болбол би бид нар гарахгүй гэж үзэж байгаа. Яагаад гэхээр энийг шууд захиран зарцуулах тийм эрх мэдэлтэй хүмүүс бол байхгүй. Их Хурлын шийдвэрийг Засгийн газар хэрэгжүүлнэ гэж бодож байгаа. Тэр Эрдэнэс таван толгойтой холбоотой асуудлыг манай ажлын хэсэг Наранцогт хариулчих уу.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 3 номер Наранцогт захирал хариулах уу? Ажлын хэсгийн 3 номерыг нээе.

С.Наранцогт: Батлут гишүүний асуултад тодруулж хариулъя. Гол нь нөгөө хувьцаа ноогдол ашиг, хувьцааны ноогдол ашгийг тараахаар бэлэн мөнгөөр, ингээд зах зээл дээр бэлэн мөнгөний нийлүүлэлт гараад инфляц үүсгэж байна гээд. Тэгэхээр яах вэ энэ өмнө ингээд 1072 хувьцааг иргэдэд эзэмшүүлэх шийдвэр гараад, ингээд хэрэгжээд явж байгаа юм. Нэгэнт иргэдийн хувьцаа болчихсон учраас бид нар ноогдол ашиг болбол тараахаас өөр арга байхгүй. Тэгээд л энүүгээрээ тараагаад явж байгаа. Харин одоо цаашид бол ер нь энэ ийм байдлаар тараах нь бас оновчгүй байна гэдэг зүйл үзээд энэ Баялгийн сангийн хуулиар

хуримтлалын сангаар дамжуулж иргэддээ ноогдол ашиг хүртээе. 1072 бол хэвээрээ явна. Энэ дээр одоо бид нар ямар ч өөрчлөлт хийх бололцоо байхгүй. Энэ бол иргэдийн өмч болсон 1072 хувьцаа. Тэгэхээр харин одоо ирээдүйд бол бид нар энэ хуримтлалын сангаар иргэдэд хуваарилна. Энэ хуваарилалт бол бэлэн мөнгөөр зарцуулагдахгүй. Эрүүл мэнд, орон сууцын зориулалтаар бэлэн бусаар боловсрол, эрүүл мэнд, орон сууцын зориулалтаар бэлэн бусаар зарцуулагдаад явна гэдэг ийм концепц явж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Та хариулт хангалттай юу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар ингээд санал хураалт явуулъя. Хаана байна вэ, зарчмын зөрүүтэй санал бэлэн байгаа биз дээ, наашаа, энд байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “салбарын” гэсний дараа “, авто зам, төмөр замын дэд бүтцийн” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Х.Ганхуяг, Т.Доржханд, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар. Цаашид ажлын хэсэг. Санал хураалт. Орно хойшоо тавьсан байгаа шүү дээ. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “иууд удирдлага” гэснийг “үйл ажиллагааны удирдлага” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.2.1, 8.3.1 дэх заалтын “иууд удирдлагыг” гэснийг “үйл ажиллагааны удирдлагыг” гэж тохиолдол бүрд нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ яагаад түрүүлээд яваад байна вэ? Харин тийм. Энэ техникийн саатал гарлаа шүү. Энэ сая санал

хураалгаж эхлээгүй байхад шууд автоматаар яваад өгсөн шүү. Энийгээ техникийнхээ асуудлыг шийдээд байх. Саяын санал хураалтыг хүчингүй болгож байгаа шүү техник түрүүлээд техник ажиллаад явсан. Тийм, хураагаагүй байхад ажиллаад явсан. Туршилтаар нэг санал хураалт явуулъя. Бүгд саналаа өгөөрэй, санал хураалт, туршилт явуулъя. Одоо ажиллаж эхэлж байна, одоо болж байна уу? Энэ одоо болж байна. Ингээд сая саналын томъёоллыг уншсан. Санал хураалт. Одоо ажиллаж байна шүү. Санал хураалт. Мягмарцэрэн нааш ир. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Хөгжлийн” гэсний өмнө “Үндэсний” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

4.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “орон сууц зэрэг суурь хэрэгцээг хангах” гэснийг “орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “төрийн сангийн нэгдсэн” гэснийг “Монголбанкн дахь төрийн сангийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

6.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.б дэд заалтын “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хурааа, хураалт. Дэгийнхээ хууль дээр яах юм бэ, за. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

7, 7 дээр манай Пүрэвдорж гишүүн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгая гэж оруулж ирсэн. Тэгээд

энийг Хууль тогтоомжийн тухай хууль дээр тийм тогтоолоор бол тогтоол зөрчиж зөрчих гээд байна Пүрэвдорж гишүүнээ. Тэгээд би таны саналын томъёоллыг би бүхлээр нь уншаадахъя эхлээд тийм. Энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.5 дугаар заалт нэмэх. 15 дугаар заалт нэмэх. Засгийн газрын 2011 оны 98, 2012 оны 116, 2012 оны 201, 2015 оны 151, 2016 оны 334, 2017 оны 154 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын иргэдийг, иргэдийн эзэмшиж байсан Эрдэнэс таван толгой хувьцаат компанийн хувьцааны хувьцаанаас хасагдсан, суутгагдсан хувьцааг тухайн иргэн хүсвэл 1072 хүртэлх нэгж хувьцааг 933 төгрөгөөр буцаан худалдан авах арга хэмжээг 2026 оны 12 сарын 31-нийг дуустал хэрэгжүүлнэ гэсэн, алив хуулийг, ийм саналын томъёолоор санал хураалт явуулж өгөөч гэж оруулж ирсэн байна.

Энд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага гэсэн зүйлийн 29.1.7 байна. Тийм байна. 29.1.6 байна. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх гэсэн энэ Хууль тогтоомжийн хуулийн заалтыг зөрчөөд байна. Тэгээд Дэгийн тухай хуулийг гаргаад ир дээ. Тийм. Өнөөдөр энэ хурал даргалагчийн эрх, үүргийн 16.2-т хуралдаан даргалагч горимын саналаар нэг удаа санал хураалт явуулна. Хуралдааныг хэлэлцэх асуудалд ороогүй асуудлаар, мөн тухайн санал нь хуулиар тогтоосон журмыг зөрчиж байгаа бол санал хураалт явуулахыг хориглоно гээд ингээд би үүрэг хүлээчхээж байгаа даргалж байгаа учраас. Тэгэхээр би энүүгээр санал хураах боломжгүй байна. Би харин ийм хууль зөрчөөд байгаа учраас Пүрэвдорж гишүүн та ойлгоорой. Би Дэгийн тухай хууль зөрчиж энэ. Та Пүрэвдорж гишүүний микрофоныг нээе.

Б.Пүрэвдорж: Дөнгөж сая мал аж ахуйн ямар, ямар юм билээ байз нэг Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж

буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн. Тэгээд энэ хэлэлцэж байхад байна шүү дээ нэг удаагийн арга хэмжээг энэ хууль дээр шууд оруулаад, тэгээд хэлэлцээд санал хураагаад дуусчихлаа. Энэ дээр жишээ нь тийм үү 6.1.9.жилийн батлагдсан төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийнэ гээд нэг удаагийн арга хэмжээ. Түүн дээрээ дахиад хэрэгжих хугацаагаа энэ дээр ингээд заачихсан байгаа. Зөвхөн 6-гийн энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтыг 24 оны 12 сарын 31-ийг хүртэл хэрэгжүүлнэ гээд ингэж 2 юм гаргаж ерөөсөө болохгүй. Энэ ийм зөвлөгөө өгч байгаа тэр сахалтай нөхөр тийм ээ, би энэ бол их маш буруу зөвлөгөө өгч байна. Өөрөөр хэлбэл бүхэл бүтэн хууль нь орж ирээд ингээд батлагдаад(кноп нь дарагдаад явж байна шүү дээ.

Гэтэл яагаад ингээд даргад буруу зөвлөгөө өгөөд, тэгээд ер нь Их Хурлын гишүүн бол ямар ч одоо асуудлаар санал гаргах зарчмын зөрүүтэй санал гаргах эрхтэй. Тэр нь тэгээд нэг удаагийнх байна уу, тэр энэ тэр нь ерөөсөө одоо юу байдаг юм тунхаглалын чанартай байна уу, тэр нь асуудал биш. Хамгийн гол нь санал гаргах эрхтэй, тэр саналыг нь хураалгах үүрэгтэй байхгүй юу даа. Энэ одоо юугаа та зөрчиж байгаа шүү. Яагаад гэвэл яг энэ асуудлаар та тайлбар хийж болно. Тэгэхдээ наадах чинь ингээд би энэ хуультай нь харьцуулаад л, өдөр болгон ийм хууль явж байгаа Цэрэнпунцаг даргаа. Тэгэхээр энэ дээр бол ингэж гишүүний гаргаж байгаа тэр саналыг ингэж хааж боогдуулж ерөөсөө болохгүй. Тэгээд та нар бол дэмжихгүй нь тодорхой наадах асуудлаараа.

Тэгэхдээ би энэ асуудлыг чинь би яг ингээд нэр заагаад, тэгэхдээ муухай юм даа нэг тойрог учраас муухай юм. Би тэгэхдээ яг ийм байдлаар эсэргүүцэж

байна гэдгийг чинь яриад явж болно шүү. Зүгээр тэгэхдээ би тэгэхгүй, ер нь бол тэгэхгүй. Тэгэхдээ би тэгэхгүй. Та тэгэхдээ би ер нь бол саналаа хураалгачих. Би энэ гишүүн бол заавал зарчмын зөрүүтэй санал гаргаад тэрийгээ хураалгах ёстой. Энэ нь бол та нарт, энэ бол та нарт эрх баригч нарт хэрэгтэй, үгүй ээ, хууль зөрчихгүй та. Би таныг хуулийг зөрчүүлэхгүй энэ, өөрөөр хэлбэл энэ Уламжлалт мал аж ахуйн хууль чинь дөнгөж сая би тэнд санал хураалт явуулагдаад, түүн дээр нь би дэмжиж кноп дарчхаад ирлээ. Өөрөөр хэлбэл бид нар бүгдээрээ хууль зөрчсөн кноп дарсан гэсэн үг. Тэгэхээр таны энэ хүний тайлбарлаж байгаагаар бол. Тийм учраас та зүгээр нэг удаагийн энэ тэр гэж тодорхойлохгүйгээр Их Хурлын гишүүний гаргаж байгаа саналыг та хураалгаад, тэгээд бараг л унах байх даа. Би тэгээд энэ асуудлаа нэг их тийм хууль зөрчихгүй л гэж бодож байна.

Ц.Цэрэнпунцаг: Энэ сая энэ Пүрэвдорж гишүүнээ би танд нэг товчхон тайлбар хэлээдэхье, хар аа Пүрэвдорж гишүүнээ. Энэ асуудал яригдаагүй биш, бид нар одоо энэ сая гаруй ирээддээ Таван толгой хувьцаат компанийн 1072 хувьцааг олгох Их Хурлын тогтоол гаргасан шүү дээ. Ингээд өнөөдрийн байдлаар Монгол Улсын сая гаруй хүүхэд 11 оны 4 сарын, 12 оны 4 сарын, 14 оны 4 сарын, 4 сарын 12-ноос хойш төрсөн одоо хамгийн ахмад одоо ахмад 10 наснаас дооших насны хүүхдүүдтэй айлууд өнөөдөр хувьцаа энэ Таван толгой хувьцаат компанийнхаа дивиденд ашгийг аваад, одоо 10-аас доош насны 3 хүүхэдтэй, 4 хүүхэдтэй айл бол сая хэдэн зуун мянган төгрөгийн дивидендээ аваад байж байна. Тэгээд энэ олон айлууд, энэ өрхүүд бол өнөөдөр хүртэл ингээд энэ саяын энэ таны дурдаад байгаа энэ 300 мянга орчим иргэд бол ингээд хувьцаагаа ерөөсөө буцаагаад зарчихсан, компанидаа зарчихсан л асуудал шүү дээ. Ингээд аваад гараад явчихсаны энэ 300 мянгаас чинь наана сая хэдэн зуун мянган энэ хувьцаа эзэмшигчид чинь энэ хувьцаагаа

өдийг хүртэл хадгалаад, өнөөдөр нэмэгдээд саяын тэр миний дурддаг сая гаруй хүүхэд ингээд нийлээд өнөөдөр энэ хувьцааныхаа дивиденд аваад ингээд байж байгаа байхгүй юу.

Тэгэхээр зэрэг энэ асуудлыг чинь бид нар энийг Их Хурлын тогтоолоор шийдээд өгсөн. Тэгээд энэ дунд бол энэ асуудал орж ирээд энэ бол хөндөгдөөгүй үлдсэн нь шударга бус байна гэсэн олон гомдол одоо энэ хувьцаа эзэмшигчдээс ирсэн юм. Тэгээд бид нар бол энийг ерөөсөө хэлэлцвэл бид нар одоо энэ шударга бус, тэгш бус байдал үүсгэх юм байна гээд энийг хойш нь тавьсан юм 1 дүгээрт.

2 дугаарт таны энийг зарчмын зөрүүтэй санал хураалгаж болохгүй байгаа шалтгаан бол 1 дүгээрт өнөөдөр энэ хурлыг удирдаж байгаа хурал даргалагч хууль зөрчиж болохгүй гээд ингээд заачихсан. Дэгийн тухай хуулийг би зөрчиж болмооргүй байна. 2 дугаарт энэ Хууль тогтоомжийн хууль дээр бүүр тодорхой хэм хэмжээ тогтоогоогүй гээд ингээд заачихсан. Тэгтэл таны энэ оруулж ирсэн энэ зарчмын зөрүүтэй гаргаж байгаа санал дээр ийм бараг 5, 6, 7 ийм Их Хурлын Засгийн газрын тогтоолуудыг ингээд дугаараар нь дурдаад ингээд оруулаад ирсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийг ингээд зөрчөөд байгаа юм.

Тэгээд таны хамгийн сүүлд сая одоо зөвтгөх үндэслэл болгоод яриад байгаа президент тогтоосон гээд байгаа энэ хууль чинь бол өнөөдөр Монгол Улсад энэ жил гамшиг болчихоод байна. Энэ хөдөө чинь энэ зуд, тэгээд төмөр мөсөн гээд л одоо өчнөөн нэр томьёотой энэ айхтар зуд болоод, энэ онцгой арга хэмжээтэй яг Ковид шиг энэ өвчин дэлхий дээр тохиолдоход нэг удаагийн онцгой арга хэмжээнүүд авсан шүү дээ. Яг энэ шиг онцгой ийм гамшигт үзэгдэл энэ жил боллоо, ийм онцгой тохиолдол болсон учраас энэ арга хэмжээг авхууль гээд авч хэрэгжүүлж байгаа хууль, нэг удаа хэрэгжих ийм хууль орж ирсэн

саяынх бол. Тэгэхээр энэтэй бол бас бид нар энийг адилтгаж одоо энэ үндэслэл болгож болохгүй байх гэж бодож байна. Тийм учраас одоо энэ дээр зарчмын зөрүүтэй санал хураалгах ийм боломжгүй байна. 7-г би сая, 7-г уншина. Сая 6 дээр санал хураалт явуулсан.

Зарчмын зөрүүтэй санал 7, 8. 7.Төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг, мөн 12 дугаар зүйлийн 12.8, 12.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 12.4-т заасан” гэснийг “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын, авто зам, төмөр замын дэд бүтцийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Баттөмөр гишүүн та микрофонд саналаа хэлье. Энэ саяын санал хураалтыг цуцалъя.

Б.Баттөмөр: Энэ санал дээр байна шүү дээ ингэж байгаа юм. Тэр авто зам, төмөр зам гэсэн юмыг оруулъя гээд тийм ээ. Тэгээд удирдлага, зохион байгуулалтаар хангана гэдэг энэ энийг одоо орохдоо бол манай Эрдэнэс Монголынхон бол тэр Таван толгой төмөр зам, Гашуун сухайт төмөр замын 66 хувийг манай Эрдэнэс Монголд эзэмшдэг учраас удирдлага, зохион байгуулалт гэдэг нь бол ТУЗ-д нь ороод явна гэдэг утгаар одоо тайлбарласан шүү дээ. Тэгээд энийг бид нар ингээд явсан. Зам, тээврийн яамныхан болохоор зэрэг одоо юу гэж байгаа вэ гэхээр энэ нэгэнт одоо Эрдэнэс Монголын харьяанд орчих юм болбол энэ мэргэжлийн яам гээд яах юм бэ гэсэн тийм юм ярьж байна л даа. Тэгэхээр бол би 1 дүгээрт бол орлого төвлөрүүлнэ, 2 дугаарт ТУЗ-д нь ороод явна л гэсэн ийм санаа гэж ойлгож байгаа шүү дээ. Наранцогт даргаа энэ дээр нэг тайлбар хэлээдэх дээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг 3 номер. Наранцогт захирал хариулъя. Нэмж тайлбар өгье.

С.Наранцогт: Нөгөө авто зам юу? Тийм. Манайх бол Гашиун сухайт авто замын эзэмшиж байгаа юм. Таван толгой төмөр замын 66 хувийг эзэмшиж байгаа юм. Тэгээд дэд бүтэц, логистикийн групптэй. Тэгээд энэ групп дээрээ бол бид нар тодорхой бас шинэ төслүүд хэрэгжүүлээд явуулах ийм л агуулгаар энэ орж ирж байгаа юм байгаа. Үгүй ээ ер нь одоо бол жишээлбэл ийм шүү дээ. Уул уурхайн төрийн өмчит бүх компани манай харьяанд ажилладаг. Уул уурхайн яам маань бол бодлогын хувьд бодлогоо гаргаад, яг аж ахуйн үйл ажиллагаагаа бол бид нар хариуцаад л явж байгаа. Энэ л зарчим шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг: Тийм, тийм. Энийгээ л бид нар бас нэг мөр ажлын хэсэг, ажлын хэсгийн ахлагч ойлголтоо нэг ийм ойлголттой байна шүү гэдгээ ер нь протоколд тусгаад нэг мөр болгож байгаа юм байна гэж ойлголоо. Энхтүвшин гишүүн саяын зарчмын зөрүүтэй саналын 7 дугаар 7-той холбоотой шүү дээ. Тийм үү? Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баттөмөр гишүүнтэй бас нэг санал нэг байна. Зүгээр удирдлага, зохион байгуулалтаар хангана гээд энэ 12.6 дээр ингээд заачихсан байна л даа. Тэгээд удирдлага, зохион байгуулалтаар хангана гэдэг бол энэ бол мэргэжлийн байгууллага тэр Монголын төмөр зам ч гэдэг юм уу, Таван толгой төмөр зам нь ч гэдэг юм уу, Зам, тээврийн яам нь энэ удирдлага, зохион байгуулалтаар л хангаад явна шүү дээ. Мэргэжлийн байгууллагын хувьд. Эрдэнэс Монгол бол юу гэдэг юм энэ төмөр замаар ч юм уу, авто замаар явж байсан орлогоо төвлөрүүлэгч, энэ баялгийн Үндэсний баялгийн сандаа төвлөрүүлж авах энэ үйл ажиллагааг л зохион байгуулна уу гэхээс биш тэр дохиолол холбоо, таталт, тавилт, тэр одоо вагон зөрүүлэг ч гэдэг юм уу, хэдэн хүн ажиллах юм эд нар юмыг чинь бүгд л одоо энэ мэргэжлийн байгууллага нь л одоо энийг удирдлага, зохион байгуулалтаар хангаад явна шүү дээ.

Хэрвээ та энийг удирдлага зохион байгуулалтаар Эрдэнэс Монгол хангаад явна гэх юм бол танай одоо юу гэдэг юм ажлын орон тоо нэлээн л нэмэгдэх байх. Тэгэхээр энэ удирдлага, зохион байгуулалт гэдэг юмаа ер нь хасвал яасан юм бэ?

Зөвхөн одоо юу гэдэг юм авто зам, төмөр зам, стратегийн ордуудын орлогыг л энэ Үндэсний баялгийн санд л төвлөрүүлэх, захиран зарцуулах үүрэг нь Эрдэнэс Монгол дээр л байна уу гэхээс биш энэ төмөр зам, авто замын удирдлага, зохион байгуулалтаар хангана гэхээр нөгөө мэргэжлийн байгууллагууддаа үгүйсгэсэн, мэргэжлийн байгууллагуудын одоо удирдлага, зохион байгуулалтаар хангаж байгаа энэ үйл ажиллагаа руу хэт их дотоод үйл ажиллагаа руу нь ингээд орсон ийм юм болчих вий дээ. Нөгөө Монголын төмөр зам чинь одоо юу гэдэг юм танайхыг удирдлага, зохион байгуулалтаар ханга ч гэдэг юм уу, тиймэрхүү юм гарах вий дээ. Удирдлага, зохион байгуулалт гэхээр. Зохион байгуулалт гэдэг чинь л одоо надад нэг эргэж харахаар юм байна даа л гэж бодож байна даа. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсэг хариулах уу? Саналаа хэлье. Энэ дээр бас нэг мөр яачихъя. 3 номер.

С.Наранцогт: Удирдлага, зохион байгуулалт гэдэг нь Компанийн тухай хуульд заасан удирдлага, зохион байгуулалтын тухай асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ нөгөө манай яг нэгдлийн харьяа компани жишээлбэл Эрдэнэт үйлдвэр энэ тэрийн бол бид нар удирдлага, зохион байгуулалтаар хангаад ажиллаж байгаа, төрөл төрлийн бүтцүүд байгаа шүү дээ. Эрдэнэс таван толгой бол хувьцааг эзэмшиж байна, хувьцаа эзэмшигч. Эрдэнэс Эрдэнэт үйлдвэр, Монрос гээд улсын үйлдвэрийн газрыг бол бид нар удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж байгаа юм. Тэгээд энэтэй ялгаагүй. Гэтэл Уул уурхайн яам

бол яг тэр олборлолт, үйл ажиллагаа, тэр бодлогын, таны ярьдаг тэр олборлолтод тавигдах шаардлага гэдэг бодлогоо гаргаад л бид нар тэрийг дагаад л явж байгаа шүү дээ. Яг удирдлага, зохион байгуулалт гэдэг бол Компанийн тухай хуульд заасан тэр удирдлага, зохион байгуулалтыг л хийж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ер нь та микрофоноо хаачхаарай, ажлын хэсэг 3 номер. Ер нь одоо энэ бас нэг ийм нэг бидэнд одоо яваад ирсэн нэг жишиг байна. Энэ яамнууд бодлого гаргана гэхээр зэрэг тэр компани өөрийнхөө бодлоготой холбоотой уялдаа холбоотой компаниудын удирдлага, зохион байгуулалт гэдэг юм нь яригдаад явчхаад байгаа юм. Бодлого гэдэг чинь бол өнөөдөр Төмөр замынхаа хуулийг гаргах, стандарт нормыг нь батлах энэ бодлогуудыг гаргаад л, тэрнийг нь хувийн ч бай, хувьсгалын ч бай дагах ёстой биз дээ. Тэр нь тэгэхээр өнөөдөр яамнууд хүртэл одоо наадах чинь ийм бодлогын яамнууд бодлогоо гаргачхаад ингээд явж байх асуудлууд өнөөдөр энэ төрийн өмчтэй компани байгаад байгаад л оршдог байх л даа. Зарим яамнууд чинь өөрөө 6, 7, 10, 10 хэдэн ийм компаниудтай болчихсон. Энэ чинь удирдлага нэгдсэн ийм зохион байгуулалттай. Ялангуяа хөрөнгө эзэмшигч талаасаа хөрөнгөө арвижуулъя, нөгөө жинхэнэ одоо компанийг ашигийн төлөө үр ашигтай ажиллуулах талаас нь ажлаа зохион байгуулж болох ажил нь ингээд орхигдоод яваад байдаг. Энийгээ одоо удирдлага, зохион байгуулалт энэ нөгөө хөрөнгө, хөрөнгөө хамгаалах гэж байгаа хөрөнгө оруулагч талаасаа харж ажиллаж байгаа талдаа олгож байгаа гэж л ойлгоод байгаа шүү дээ, Наранцогт захирлаа тийм ээ. Тэгэхээр бол удирдлага, зохион байгуулалт гараад, энэ үг нь эндээ байвал зүгээр байгаа шүү ер нь. Тэгээд үүгээрээ явчихвал яах вэ, Баттөмөр дарга, Баттөмөр гишүүнээ, тийм. Тийм байна. Би та бүхэнд сая уншаад танилцуулчихсан учраас санал

хураалт явуулъя. Санал хураалт. Санал гишүүдийн 54,5 хувь нь дэмжлэг санал дэмжигдлээ.

8.Төслийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсгийн “ордын төрийн эзэмшлийн хувийг” гэснийг “ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

9.Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “эзэмшлийн” гэснийг “төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох” гэж өөрчлөх Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

11.Төслийн 16 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

12.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

8.1.Сангийн эх үүсвэрийг холбогдох журмын дагуу хуваарилалт хийснээс хойш ажлын таван өдрийн дотор

Монголбанкн дахь Сангийн дансанд ижилжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг, 8.3 дахь хэсгийн, 9¹ дүгээр зүйлийн 9¹.1 дэх хэсгийн “энэ хуулийн 7.1-д заасан” гэснийг “Сангийн” гэж тус тус өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ дээр энэ хаяад бичигдсэн байна, тийм байгаа биз. Энд орхигдсон байна шүү. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн гарчгийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 5³ дугаар зүйлийн “Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.2-т” гэснийг “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.б-д” гэж тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 53 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “33.2.11” гэснийг “33.2.10” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 33 дугаар зүйлийн 33.2.10 дахь заалтын “33.2.6-д” гэснийг “33.2.6, 33.2.10-д” гэж, мөн зүйлийн 33.2.10 дахь заалтын дугаарыг “33.2.11” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “5.3.27” гэснийг “5.3.26” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт буюу 21.1.16 дахь заалт, 30.14 дэх хэсгийн “Төрийн болон орон нутгийн өмчит /өмчийн оролцоотой/” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйл буюу 30.10.1 дэх заалтын “ашигт малтмалын” гэснийг “стратегийн ач

холбогдол бүхий ашигт малтмалын ордын” гэж өөрчилж, мөн зүйлийн 30.10.2 дахь заалтын “бусад тохиолдолд” гэсний өмнө “энэ хуулийн 30.10.1-д зааснаас” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “сангийн” гэсний дараах, мөн зүйлийн “орлого,” гэсний дараах “хөрөнгө оруулалтын орлого” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 5.7 дахь хэсгийн “20-оос” гэснийг “34-өөс” гэж өөрчилж, мөн хэсгийн “эзэмших” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 29 дүгээр зүйлд. 2 дроб шүү дээ. Гишүүдийн, тийм байна, уучлаарай, энэ саяын миний энэ төхөөрөмж ажилласангүй. Ингээд саяын хураасан санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Миний төхөөрөмж ингээд заримдаа гацаад байх юм. Даргын төхөөрөмж энэ, харин тийм энэ юу нь халираад, кноп мөлийгөөд халцарсан байна. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж саяын санал хураалт хүчингүйд тооцлоо. Ингээд саяын санал хураалт хүчингүйд тооцогдсон учраас санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Миний энэ аппарат ингээж хүчтэй дарсаар байгаад хээ нь арилад халцарсан байна. Гишүүд саналаа өгсөн үү, санал өгсөн үү, анхааралтай байгаарай гишүүдээ. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн мөн үү, Төслийн 1 дүгээр зүйлийн 5.8 дахь хэсгийн “хуулийн этгээд /төрийн өмчийн оролцоотой болон орон нутгийн өмчийн

оролцоотой хуулийн этгээд/-ийн” гэснийг “, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “гэрээ байгуулсан” гэсний дараа “тохиолдолд тухайн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 2/9 дүгээр зүйл шүү дээ энэ чинь. Хэнийх вэ? Энхтүвшин гишүүний төхөөрөмж гацах шиг боллоо. Санал гаргана уу.

Т.Энхтүвшин: Энэ миний төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг дахиж явуулж өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн санал гаргалаа. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Төхөөрөмжтэйгөө харьцаж, зүй бус харьцанаас болоод төхөөрөмж нь, гоё ингэ л дээ илээд л. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал хүчингүй боллоо. Ингээд саяын санал хүчингүй болгосон тул санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Зүй бус харьцаж байгаа. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн “5.9.Иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан энэ хуулийн 5.7-д заасан хуулийн этгээдийн хувьцааг шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2/9 дүгээр зүйлийн 9.1.16, 9.1.17 дахь заалт:

9.1.16.энэ хуулийн 5.7-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийг удирдах, хуулийн хэрэгжилтийг хангуулах бүрэн эрхт төлөөлөгчийг томилох;

9.1.17.энэ хуулийн 9.1.16-д заасан бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах

журмыг энэ хуульд нийцүүлэн батлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг:

“5.4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашигласан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны 50 хүртэлх хувийг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болох бөгөөд төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоож болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.

5.5.Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр үнэ төлбөргүйгээр эзэмшиж болно. Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно.”

2/8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт:

8.1.7.Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачилгаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох болон

ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх.”

3/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

9.1.5.энэ хуулийн 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тийм. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

6.Төслийн гарчгийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дэх заалтын “холбогдуулан” гэсний дараа “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигласны үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр” гэж нэмж, мөн заалтын “2029 оны 1 дүгээр улиралд багтаан” гэснийг төслийн 1 дэх заалтын 1.2 дахь дэд заалтын “боловсруулж,” гэсний дараа ишлжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж,

2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;" Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ нэлээн шахуу даалгавар өгч дээ тийм ээ, бэлэн юм уу. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

"4/Монгол Улсын иргэн бүрд 2024 оны 2 дугаар улиралд багтаан хуримтлалын нэрийн данс үүсгэх;" Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ нэрийн данс үүсгэх бол бараг бэлэн юм байгаа биз дээ? Тийм. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

"5/Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Хуримтлалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Хуралд, энийгээ зөв бич л дээ. Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Та нарын зүрхийг Монгол Улсынхаа баялгийг та нар чулуу болгож байгаа гэж бодож зүрх чинь бас цус чинь буцлах ёстой шүү дээ. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

"2.Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн дансыг Монголбанкн дахь төрийн сангийн дансанд үүсгэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д даалгасугай." Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэн тэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, заалт, дэд заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бичгээр ирсэн санал байгаа юу? Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс бичгээр ирүүлсэн санал алга байна. Ингээд санал хураалт явуулж дууслаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр танилцуулна. Баярлалаа. Ажлын хэсэг явж болно.

15.44 цаг

Дөрөв. Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайлан

Дараагийн хэлэлцэх асуудал. Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэнэ. Ажлын хэсгийг оруулна уу. Ажлын хэсгээ оруулаад ирээрэй. Батдаваа дарга байна уу? Батдаваа дарга танилцуулгаа хийж байя. Микрофоныг нь нээнэ. Ажлын хэсгийн 1 номерын микрофоныг нээе.

Б.Батдаваа: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг та бүхэнд толилуулъя. Бид өнгөрсөн онд албан ёсны статистикийг хөгжүүлэх, дэлхий нийтийн чиг хандлага, дотоодын хэрэгцээнд нийцүүлэн статистикийн салбарыг 2021 оноос 2025 онд хөгжүүлэх

дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллалаа. Энэхүү стратеги төлөвлөгөөнд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүний нөөцийг бэхжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, статистикийн мэдээлэл эрхлэн гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилтуудыг дэвшүүлсэн. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийг нэгтгэж боловсруулахад Үндэсний статистикийн хорооноос баталж зөвшөөрсөн 78 аргачлал, 11 ангиллыг мөрдөж байна.

Үндэсний статистикийн хорооноос статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх ажлын хүрээнд 2023 онд 7 аргачлал, 6 судалгааны үзэл баримтлал, 5 маягт, түүнийг нөхөх заавар, 5 гарын авлага, 8 судалгааны үр дүн, танилцуулгыг шинээр болон шинэчлэн боловсруулсан. Үүнээс шинээр 3 аргачлал, 4 судалгааны үзэл баримтлал, асуулга нөхөх заавар 7 гарын авлага, баримт бичгийг боловсруулж баталлаа. Үндэсний статистикийн хороо статистикийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өнгөрсөн онд улсын хэмжээнд 1 тооллого судалгаа, 18 түүвэр судалгааг зохион байгуулж, сард дунджаар давхардсан тоогоор 29,1 мянган аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг нэгтгэн нягталж, 3,2 мянган өрхөөс мэдээлэл цуглуулж, статистик мэдээллийг боловсруулж ажиллалаа.

Тухайлбал, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны салбарын албан ёсны статистикийн мэдээг өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас 7 хоног, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар нэгтгэн боловсруулсан бол хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, боловсрол, шинжлэх ухаан, соёл, мөнгө, зээл, санхүү, гааль, даатгал, татвар, байгаль орчин, шүүхийн статистик зэрэг захиргааны мэдээллийг

нийт 44 байгууллагаас боловсруулж, хэрэглэгчдийн хүртээл болголоо. Бид 2023 онд Статистикийн тухай хуульд заасны дагуу тогтмол зохион байгуулдаг тооллого, түүвэр судалгаануудаас гадна Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан Зөвлөлдөж шийдье 2 шатын зөвлөлдөх санал асуулга, 5 жил тутам зохион байгуулдаг нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, цаг ашиглалтын судалгаа, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа зэрэг улсын хэмжээний томоохон түүвэр судалгааг зохион байгууллаа.

Статистикийн тухай хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Монгол Улсад анх удаа хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэгт өртөх эрсдэл, нөлөөллийг судлах, гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг Нэгдсэн Үндэсний Байгууллагын хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны зөвлөмжийн дагуу зохион явууллаа. Мөн 5 жил тутам зохион байгуулдаг хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, хөгжил, хамгаалал, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн мэдээллийн технологийн хэрэглээ, түүний ур чадвар, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тооцох, нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүүхдийн сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сантай хамтран амжилттай зохион байгууллаа.

Бид статистикийн мэдээллийн хамрах хүрээ, чанарыг сайжруулах зорилгоор өнгөрсөн онд статистикийн үйл ажиллагааны ерөнхий загварын дагуу мэдээлэл цуглуулалтаас тархаалт хүртэл бүх алхмыг цахимжуулсан, статистикийн үйлдвэрлэлийн системийн нэвтрэлтийг нэмэгдүүлэх, дотоод үйл ажиллагаагаа бүрэн цахимжуулах, түүвэр судалгааны мэдээллийг хянах, цахим мониторингийн системийг нэвтрүүлэх зэрэг ажлыг шинээр хийж хэрэгжүүллээ. Мөн улсын хэмжээнд мэдээллийг нягтлах,

уялдуулах, шалгах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд зөрүүтэй мэдээллийг шинэчилж, статистикийн үйл ажиллагаанд мэдээллийн чанарыг цаашид хангах үйл ажиллагааны цогц журам, загварыг хөгжүүлэн ажиллаж байна. Хэрэглэгчдийн статистик өгөгдлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг чанартай эх үүсвэрээр хангах нь Үндэсний статистикийн хороо төдийгүй дэлхийн орнуудын улс орнуудын статистикийн байгууллагын өмнө тулгарч буй зорилт хэвээр байна. Уг хэрэгцээг манай улсын онцлог, хязгаарлагдмал нөөцөд тулгуурлан мэдээллийн технологийн ололтод түшиглэн ишийдвэрлэх зорилгоор Үндэсний статистикийн хорооноос 2021 оноос 2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд захиргааны өгөгдөлд суурилсан төрийн нэгдсэн мэдээллийн сан, төрийн их өгөгдөл төслийг хэрэгжүүлэх зорилт тавьсан.

Энэ зорилтын хүрээнд өнгөрсөн онд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага, төслийг Үндэсний статистикийн хороо хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд төрийн байгууллагуудын өгөгдлийн сангийн чанарыг үнэлэх, албан хаагчдыг чадавхжуулах, төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан болон өгөгдлийн нэгдсэн санг үүсгэж эхлээд байна. Мөн статистикийн шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоог сараар тооцох, цахим хуудаснаас шүүх, өгөгдөл холбох зэрэг статистикийн шинэ эх үүсвэрүүдийг бий болгож ажиллалаа.

Хэрэглэгчид статистикийн мэдээллийг хялбар хүргэх зорилтын хүрээнд бид 2023 онд хэвлэмэл болон цахим хуудсаар 26 салбарын 569 мэдээллийг шинэчлэн, олон нийтэд тархааж, статистикийн мэдлэг, боловсролыг сайжруулах сургалтуудыг зохион байгууллаа. Статистикийн салбарын гадаад харилцааг өргөжүүлэх

зорилгоор өнгөрсөн онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Статистикийн товчоог Үндэсний статистикийн хорооны дарга даргалж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн комисс бүсийн уулзалтад Монгол Улсын статистикийн систем болон бүсийг төлөөлж ажиллалаа. Бидний гадаад хамтын ажиллагааны үр дүнд Үндэсний статистикийн хороонд 2023 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилт бүхий техник туслалцааны төсөл ч хэрэгжиж эхэлсний зэрэгцээ Бүгд Найрамдах Солонгос Улсын Статистикийн газраас 2024-өөс 2007 он 2027 онд Монгол Улсад хэрэгжүүлэх статистикийн системийг хөгжүүлэх хөгжлийн албан ёсны тусламж батлагдлаа.

Мөн 2 талт хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улс, Гүрж Улс, Бүгд Найрамдах Польш Улсын Статистикийн байгууллагатай санамж бичиг байгуулж, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Австралийн Холбооны Улсын статистикийн байгууллагуудтай хамтран ажиллах тохиролцоонд хүрлээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтарч үндэсний статистикийн системийн цогц үнэлгээг хийж, үнэлгээний мөрөөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын дэргэдэх 21 дүгээр зуунд Статистикийн хөгжлийн төлөөх түншлэл байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Үндэсний статистикийн тухай хуулийн төслийг шинэчлэх, шинэчлэн боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

2024 онд бид Төрийн нэгдсэн мэдээллийн сан төслийн хүрээнд үндэсний өгөгдлийн платформ, мета өгөгдлийн платформын эхний хувилбарыг ашиглалтад оруулж, мэдээллийг нэгтгэх, задгай өгөгдөлтэй

ажиллах орчныг бүрдүүлэх эхний алхмыг хийнэ. Мөн статистикийн мэдээллийн хамрах хүрээ, чанарыг сайжруулах, мэдээллийн зөрүүг арилгах, нэгтгэх, Монгол Улсын түүхийн статистик үзүүлэлтүүдийг баяжуулах зэрэг ажлуудыг хийж эхлээд байна. Түүнчлэн статистикийн салбарын 100 жилийн тэмдэглэлт ойн хүрээнд бид 2 талт болон олон улсын хэмжээний 6 арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулахаар төлөвлөөд байна. Энэ онд бид статистикийн системийн мэдээллийн чанарыг сайжруулах, шинэ эх үүсвэр бий болгох, улсын хэмжээнд өгөгдлийн засаглал, шинжлэх ухааныг бэхжүүлэх ажлуудад голлон анхаарч ажиллана. Үндэсний статистикийн хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланд анхаарал хандуулсан та бүхэнд талархал илэрхийлье, баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийг танилцуулъя. Батдаваа даргад баярлалаа. Танилцуулга хийсэнд. Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Лхамсүрэн Үндэсний статистикийн хорооны дэд дарга, Оюунжаргал тус хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга, Оюунцэцэг тус хорооны Нийгмийн статистикийн газрын дарга, Ш.Ариунболд тус хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын дарга, Тэгшжаргал тус хорооны Нэгдсэн статистикийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мягмарханд тус хорооны Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга, Даваажаргал тус хорооны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ундрал тус хорооны Нийгмийн статистикийн газрын Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн дарга, Оюунбилэг тус хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Өгөгдөл, судалгаа шинжилгээний хэлтсийн дарга, Мандахзориг тус хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон

сууцын тооллогын хэлтсийн дарга, Цэрэнханд тус хорооны Нэгдсэн статистикийн газрын Үндэсний тооцооны хэлтсийн ахлах статистикч. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Манай Статистикийн газрын гарч байгаа тайлан мэдээ болбол одоо цаг хугацаандаа бас аятайхан гарч байгаа. Тэгэхээр 2 асуулт байна. 1 дүгээрт нь энэ шинжлэх ухаан, технологийн ололт, тэр хиймэл оюун ухаан, блокчэйн технологи гээд одоо энд суурилсан дэлхийн статистикийн байгууллагын чиг хандлага ер нь ямар байна, манайх ямар түвшинд байна, юу хийж болох боломжууд байна гэж? Нэг статистик унидаггүй ч гэсэн рейтингээ унш, рейтингээ унидаггүй ч гэсэн статистик унших гэж тийм ээ, үг байдаг. Тэгээд ер нь статистик гэдэг болбол шийдвэр гаргах, бодлого боловсруулах, алс хэтээ харах гол юм чинь л одоо статистик байгаа юм л даа. Тэгээд манайхан харамсалтай нь энийг их бага унидаг юм байгаа юм.

Тэр 2 дахь асуулт болбол энэ та нар бол тоо гаргачхаж байна. Шинжилгээ яаж хийдэг юм бэ, шинжилгээ яаж хийдэг юм бэ? Тухайлбал, бүтээмж гэж нэг үзүүлэлт байгаа шүү дээ тийм ээ. Бид нар чинь одоо тэтгэврийг 100 мянган төгрөгөөр нэмнэ, цалинг 4 сарын 1-нээс эхлээд 10 хувиар нэмнэ ингээд одоо улс төрийн шийдвэр гарчхаж байгаа юм л даа. Тэгээд яах вэ, ер нь бол манай тэтгэврийн хэмжээ бага байгаа, цалингийн хэмжээ бага байгаа, нэмнэ гэдэгтэй болбол санал нэг, 100 хувь санал нэг байгаа. Нэмэхдээ юу гэхээр зэрэг одоо тэр бүтээмж гэдэг юмаа нэмж байж, үр ашгаа нэмж байж одоо тэр цалин, тэтгэвэр нэмэх ёстой юм тийм ээ. Тэгэхээр болбол яг бүтээмж, тоо хэлэх үү та нар, 21 онд Монгол Улсын нийт эдийн засгийн бүтээмжийн хэмжээ ямар байсан юм 21 онд, 22 онд хэд байна,

23 онд хэд байна, 24 онд ер нь хэд гарах боломж байна гэсэн ийм тооцоо? Та нар дээр мэдээж байгаа байх л даа. Тэр статистикийн ном дээр бол юм байдаггүй.

Дараагийн асуулт болбол нөгөө үр ашиг гэдэг үзүүлэлт байгаа юм маржсин. Нийт Монгол Улсын экспортод гарч байгаа бараа, бүтээгдэхүүн Монгол Улсад орж ирж байгаа мөнгө, ямар хэмжээний бараа, бүтээгдэхүүн гараад, ямар хэмжээний мөнгө орж ирэв, зардал нь ямар гарав, үйл ажиллагааны үр ашиг ер нь ямар байдаг юм бэ, та нар энэний тооцоо судалгаа хийдэг үү гээд. Би зүгээр уул уурхай дээр түшиглэж ярьж байна. Мэдээж бүх салбарт гарах байх, хөдөө аж ахуй, зам тээвэр гээд. Тэгээд энэ дээр ийм юм байх уу, үгүй юү? Үр ашгийн одоо маржсин, нийт хэмжээ нь нийт хэчнээн хэмжээний баялаг гарч байна, энэнээс татварт хэдэн төгрөг ордог юм бэ? Хамгийн гол үзүүлэлт энэ шүү дээ. Баялгийн эзэд Монголчууд, Монгол хүн. Тэгэхээр асар их хэмжээний баялаг гараад байдаг, ямар үнээр гараад байдаг нь тодорхойгүй. Үгүй ээ, тодорхойгүй ч гэж дээ, ойлгомжтой шүү дээ. Оросын Холбооны Улсын гаргаж байгаа үнээс нүүрс гээд л тэгтэл 20 хувь, дэлхийн зах зээлийн үнэ Австралийнхаас 50 хувь хямд байгаа шүү дээ. Тэгэхээр манай энэ үр ашгийн маржсин гэдэг юм ямар байдаг юм бэ? Салбарын яамнууд дээр бол гарах л байх. Тэгэхдээ манай статистикийн байгууллага дээр ямар тооцоо судалгаа байдаг юм бэ? Энэ дээр үндэслэж л цаашидаа бид чинь үйл ажиллагаа, бодлогоо л тодорхойлох л шаардлагатай байгаа юм л даа. Тэгээд ийм мэдээллүүд их хомс байна. Та нарт ийм мэдээллүүд байна уу, гаргаж болох уу байхгүй бол? Ийм асуултуудад хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 1 номер Батдаваа дарга хариулах уу? 1 номерыг нээе.

Б.Батдаваа: Эрхэм гишүүн Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Шинжлэх ухааны ололт буюу энэ хиймэл

оюун ухаан блокчек технологийн хувьд бол дэлхийн улс орнуудын статистикийн байгууллагууд дээр ололт амжилтыг ямар хэмжээнд хэрэгжүүлж ажиллаж байна гэдэг дээр бол асуулт асуулаа. Хамгийн наад захын жишээ бол энэ статистикийн мэдээллийг хайх дээр бол энэ хиймэл оюун ухааны чатботтой ижилхэн бүтээгдэхүүнийг сүүлийн үед бол ашиглаж байна. Энэ дээр бол Олон улсын валютын сангаас эхлээд туршилтын хөгжүүлэлтийг хийгээд явж байгаа статистикийн байгууллага дээр ашиглахаар.

Монгол Улсын хувьд бол бид нар Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын доор байдаг Парис 21 гээд байгууллагатай хамтраад энэ англи хэлнээс өөр хэл дээр энэ хиймэл оюун ухааныг ашиглах, чатбот хөгжүүлэх юу туршилтыг бол хийе гэдэг ийм яриа хэлцэл хийгээд явж байгаа. Дээрээс нь бид бас Төрийн нэгдсэн мэдээллийн сан гээд төсөл Азийн хөгжлийн банк болон Солонгосын дэмжлэгтэйгээр бол хэрэгжүүлж байгаа. Энэ төслийн хүрээнд бол бас энэ статистикийн байгууллагынхаа 100 жилийн ойн хүрээнд буюу энэ 11 дүгээр сард энэ хиймэл оюун ухаанд суурилсан чатботыг бас оруулъя гэдэг ийм зорилтыг тавиад явж байгаа. Ер нь бол яах вэ төрийн байгууллагууд дээр тулгамдаж байгаа нэг асуудал бол хүний нөөцийн тулгамдсан асуудал байгаа. Одоохондоо бол бид нар энийг гаднын техник туслалцаа төсөл хэрэгжүүлэх замаар бол шийдвэрлээд яваад байна. Одоо тэрийг харин цаашид яаж тогтвортой нутагшуулж авч үлдэх вэ гэдэг дээр бол олон улсын байгууллагууд бол бид манай байгууллага бол бас анхаараад хүнээ сургах гээд энэ төслийн хүрээнд бол ажлууд хийгээд явж байгаа.

2 дугаар асуултын хүрээнд Монгол Улсын бүтээмжийн асуулт байгаа. Яг одоо бид нарын бэлэн гаргаж байгаа нэг ажилчдын нэмэгдэл өртгийн тоон мэдээллийг бол Баттөмөр дарга байнга авч ашиглаж байгаа. 23 оны байдлаар

бол нэг ажилчдын дундаж бүтээсэн нэмэгдэл өртөг бол 24,8 сая төгрөг буюу 22 оноосоо бол 8,9 орчим хувиар нэмэгдчихсэн байгаа. Энийг салбараар нь харахаар ажиллах хүчний оролцоо хамгийн бага, капиталын орц ихтэй уул уурхайн салбар бүүр 60 орчим сая байхад, нөгөө хөдөлмөрийн оролцоо нэлээн өндөр нийт ажиллах хүчний 22 хувь нь ажилладаг хөдөө аж ахуйн салбар жилдээ нэг ажилчин нь 13,5 сая төгрөгийн л нэмэгдэл өртөг бүтээгээд байгаа гэдэг ийм статистик мэдээ гарч байгаа. Яг одоо бас бүтээмжийг нийлбэр үйлдвэрлэлийн хүчин зүйлээр нь тооцох энэ тооцооны судалгааг бол бид мэдээллийг нь бол мэдээллээ гаргаад, Азийн бүтээмжийн байгууллагад өгөөд, эндээс бол бусад улсын бүтээмжийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан байдлаар судалгаанууд гарч байгаа.

Энэ судалгааг харахад бол түүхэн динамикийг харахад бол 1990 он хүртэл бол Монгол Улсын бүтээмжийн өсөлт бол капиталын буюу хөрөнгө оруулалтаар их явж байгаад, 90-ээс 94 он хүртэл буураад, 94-өөс 2005 он хүртэл болохоор зохицуулалтуудын хялбаршуулалт буюу нөгөө чөлөөт зах зээлийн зарчмаар бүтээмж бол нэмэгдсэн гэдэг ийм статистик байдаг. Энэнээс хойш 2006 оноос хойших уул уурхайн гол нэмэгдлийн хувьд бол дандаа юугаар аваад байгаа капиталын орцын нэмэгдлээр илүү бүтээмж нэмэгдэж яваад байгаа. Яг нөгөө нэг ажилчдын өөрийнх нь ур чадвар нэмэгдэж байгаа, дээрээс нь технологийн шилжилтийн орцууд нь бол хамаагүй бага яваад байгаа. Тэгэхээр бид нар бол энэ нөгөө.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Батдаваа гүйцээгээд хариулчихъя, 1 номерын микрофоныг нээе.

Б.Батдаваа: Тэгэхээр энэ дээр бол нөгөө хувийн хэвшил болон эдийн засгийн нөгөө үр ашигтай байдлыг хангах зохицуулалтууддаа бас анхаарах ёстой юм болов уу гэж харагдаад байгаа. Дан

ганц нөгөө капиталаар бүтээмж өсөөд байна гэж харагдаад байгаа манай судалгаагаар. Манай юуны эдийн засгийн салбаруудын маржинуудыг Тэгшжаргал дарга хариулчих уу салбар болгоноор нь.

Ц.Цэрэнпунцаг: 3 номер дээр сууж байгаад хариулчих. Наадах чинь ажиллахгүй. Тэгшжаргалаа 3 номер, ажлын хэсгийн 3 номер дээр суучих.

Ц.Тэгшжаргал: Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Салбарууд болбол салбаруудын нэмэгдэл өртгийн одоо тоонуудыг бол харуулъя. Нэмэгдэл өртгийг ер нь тооцохдоо бол бид нар оны болон зэрэгцүүлэх үнээр тооцож байгаа. Зэрэгцүүлэх үнийн тооцооны хувьд болбол салбаруудын хувьд бол харилцан адилгүй байгаа. Мэдээж манай уул уурхайн салбар бол нийт нэмэгдэл өртөгтөө болбол нэлээдгүй өндөр хувийг эзэлж байгаа. Тэгээд 2023 оны 4 дүгээр улирлын, жилийн эцсийн байдлаар болбол зэрэг 2023 онд уул уурхайн салбар дээр болбол 3,8 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бүтээгдсэн байгаа болбол хөдөө аж ахуйн салбар дээр зэрэгцүүлэх үнээрээ мөн 3 аравны, 3 их наяд 873 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртөг бүтээгдсэн байна. Харин үйлчилгээний салбаруудын хувьд болбол бас мөн харилцан адилгүй байгаад байна. Үйлчилгээний салбаруудаас нэмэгдэл өртөг нь бол нэлээдгүй их байдаг салбар болбол тээврийн салбар байгаа. Тээврийн салбарын хувьд бол нэмэгдэл өртөг 2023 оны байдлаар болбол 1,7 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бол бүтээгдсэн байна гэх мэтчилнээр болбол салбар болгонд бол харилцан адилгүй байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Та хариултаа гүйцэт авсан уу, тодруулж асуух уу? Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Яах вэ, ер нь зүгээр тоонууд хэллээ тийм ээ. Уг нь харьцуулж л хэлж байх, хэлэх ёстой юм. Урьд он, урьд онтойгоо ингэсэн байна, ийм

хэмжээний одоо үр ашиг гарч байна гэж. Үр ашиг асуугаад байгаа шүү дээ тийм ээ. Түүнээс биш тэр нэмэгдсэн өртгийн тэр тоо болбол асуугаагүй. Тийм учраас танай дээр бол байхгүй байх. Энийгээ та нар өөрсдөө яах вэ, зүгээр та нар дээр байдаг байж магадгүй байх. Мэдээлэлгүй учраас бидэнд мэдээлэл алга байна л даа. Тийм учраас тооцоо их сайн хийх ёстой. Ер нь бол манай статистикийн байгууллага бол зүгээр ажлыг нь бид нар ярьж байна, гайгүй сайн ажиллаж байгаа. Энийг бол ингэж дүгнэж байгаа. Би бас статистик бас нэлээн сайн хардаг юм. Тэгээд одоо байхгүй юмыг Батдаваа дарга руу ярьж байгаад авдаг юм. Тэгээд та нар энэ тооцоонуудаа их сайн хийгээрэй. Ер нь үр ашиг, ер нь эцсийн эцэст бүх юмны чинь суурь төгсгөлийг бол үр ашиг шүү дээ. Үр ашиг л асуугаад байгаа юм. Ямар.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Хариулт болсон. Батдаваа дарга гүйцээгээд хариулчих. Битгий дараарай. Байж бай, өөрөө асна. Ажлын хэсгийн 1 номерын микрофоныг нээнэ үү.

Б.Батдаваа: Баттөмөр даргын асуусан тэр нөгөө үр ашгийн тооцоо бид нарт байгаа. Тэгээд яг одоо нөгөө бэлэн бэлдээгүй байна. Тан руу бас тусгайлан хүргүүлбэ. Ер нь яг ерөнхий дүнгээр нь тооцоог харахаар манай дээр нэг ийм зүйл ажиглагдаад байдаг. Цалин, нэмэгдэл өртгийн, нөгөө цалингийн эзлэх хувь нь дунджаараа дэлхийн дунджаас бол бага байгаад байдаг. Өөрөөр хэлбэл нөгөө талдаа нөгөө нийлбэр ашиг гэж бид нар яг статистикийн хэллэгээрээ хэлээд байдаг, тэр нь өндөр байгаад байдаг. Тэрийг шууд одоо нөгөө капиталын эзэмшигчид нь илүү ашиг олоод гэж хэлж болохгүй. Яагаад гэхээр нөгөө салбараараа бас ялгаатай харагдаад байгаа. Тэрийг бас эрсдэлийн түвшинтэй нь бас харьцуулсан тийм улс орнуудтай бас харьцуулж харах ёстой болов уу. Тэгээд салбараар нь Баттөмөр дарга руу бид хүргүүлбэ.

Ц.Цэрэнпунцаг: Та нэмэлт асуулт асууя. Баттөмөр гишүүн нэмэлт асуулт асууя.

Б.Баттөмөр: Бид нарын ерөөсөө ажлын гол эцсийн үр дүн бол үр ашиг шүү дээ. Монгол Улсын Ерөнхий сайд, Их Хурлын дарга, яамдын сайд нар энэ үр ашгаа мэдэж байх ёстой. Уул уурхайн сайд ямар юм хийгээд байгаагаа, салбарын үр ашиг ямар байгаа юм, хөдөө аж ахуйн сайд бол энийгээ бас мэдэж байх ёстой. Тийм учраас та нар статистик мэдээлэл гаргахдаа бас үзэж байгаад энэ үр ашгийн юмнуудыг та нар үзээч бас ийм хангалттай бас танайх чинь боловсон хүчин байна, боломжууд байна. Энэ статистик мэдээндээ үр ашгийн үзүүлэлт, бүтээмжийн үзүүлэлтүүдийг 2 гол үзүүлэлт энэ байна шүү дээ. Тийм учраас энийг тэр статистик мэдээн дээрээ салбар болгоноор гаргадаг сан уу, шийдвэр гаргах түвшинд одоо ингээд л өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүд хууль тогтоохдоо тэр танай тэр үзүүлэлтүүдийг л их сайн харах ёстой юм байгаа юм л даа. Тэр утгаар одоо би асууж байгаа юм. Үнэхээр хамгийн гол нь бол тэр л байгаа. Надад бол үгүй шүү, би бол ерөнхийдөө бол ойлгоно, мэднэ. Тийм учраас энийг та нар өөрснөө анхаарна биз дээ.

Ц.Цэрэнпунцаг: Батдаваа дарга, Үндэсний статистикийн хорооныхон та бүхэн бас энэ Баттөмөр гишүүний хэлж байгаа, сануулж байгааг бас анхааралдаа авч, цаашидаа ажилдаа тусгах хэрэгтэй шүү. Ер нь одоо бас энэ Эдийн засгийн байнгын хороон дээр нэг байнга яригдаад байгаа зүйл бол бид нар энэ бүтээмжийн талаар их ярих шаардлагатай болсон. Нэг талдаа цалин пүнлүү нэмэгдэж байдаг. Ялангуяа төрийн албан хаагчид бол цалин их нэмэгдэж байгаа, тэгээд инфляц үүсэж байгаа үед бол бас бид нар болгоомжилж ярьдаг зүйлүүд бүтээмжтэйгээ холбоотой өсөж байгаа юм уу, үгүй юү энэ чинь одоо юу болж байна гээд асуулт их гардаг. Одоо яг бодлого гаргагчдад бол

энэ мэдээлэл шаардлагатай. Тэгэхээр Батдаваа дарга та ер нь цаашидаа бас энэ эрэлт шаардлагад нийцүүлж гаргаж байгаа та бүхэн бүтээгдэхүүнээ зах зээлийн зарчмаар нийлүүлэх тал дээр ажиллаарай.

Ялангуяа бид нар энэ эдийн засгийн өсөлт гэдэг юмыг их сайн ярих цаг болсон. Эдийн засгийн өсөлт хаанаас ирдэг юм бэ гэдгээ бид нар бодлого гаргагчид энд бас тодорхой хэмжээний ойлголттой байх ёстой. Одоо тэр бүүр нарийн мэргэжлийн эдийн засагчдын хэмжээнд биш гэхэд тийм үү? Өсөлтийн ялангуяа ярьдаг 2 гол үндсэн зүйл бол капиталын гүнзгийрүүлэлтээс ирж байгаа, тийм ээ. Энэ бол манайд хамгийн гол юм нь. Тэрнээсээ ялгаад дахиад TFP гэж байгаа тийм ээ, энийгээ бид нар ялгаж бас үзээд, аль нь одоо бид нарын капиталын гүнзгийрүүлэлтээс ирж байгаа юм бэ? Дээрээс нь ялангуяа ажлын байрнууд нэмэгдэж, хүн ам бид нар чинь залуу улс орон тийм ээ, ер нь ажиллах хүчинд бол залуу шинээр орж ирж байгаа энэ орц, ажиллах хүчний нэмэгдэж байгаа, дээрээс нь нөгөө талдаа ажлын байр нэмэгдээд энэ эдийн засгийн өсөлтүүд ирж байгаа. Тэгээд уул уурхай дээр бол та бүхэн хэлж байгаа онцлогтой ялгаатай ингээд. Энэ эдийн засгийн өсөлтийн ирж байгаа энэ эх үүсвэрүүдийг нь ингээд бас нарийн ялгаж өгөөд, бас ойлголт бид нарт өгүүлэх хэрэгтэй байгаа.

Өнөөдөр бид нар ерөөсөө эдийн засгийн өсөлт гэхээр зэрэг зүгээр л нэг наймаа, гадаад худалдааны асуудал болоод л явчих гээд байгаа шүү дээ. Экспорт хэд орж ирж байна, хэд гаргаж импорт хийж байна, тэгээд зөрүү орж ирээд энэ төсөөллийнхөө зардал чирэгдэл дээр нэмж, хасаад балансыг нь хараад, тэгээд л ерөөсөө бид нар чинь нэг ийм ерөнхийдөө л тэр эдийн засгийн хэсэг ойлголтыг бол тэр санхүүгийн ашиг талаас нь ч юм уу ийм явцуу нэг өнцгөөр нь хараад байгаа. Нийтдээ бид нар тэр өсөлтийн эдийн засгийн өсөлт гэдэг тэр энэ ойлголтыг бид нар статистикаар

ямар нэгэн тоо баримт шаардахад задлаад гаргаад харуулаад ингээд тавьчихдаг байвал хэрэгтэй байна гээд байгаа нь, ялангуяа та бүхэн бол сайн ажил хийж байгаа. Батдаваа дарга сайн ажил хийж байгаа. Яагаад гэвэл бид нар байнгын энэ эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн мэдээллийг бол Эдийн засгийн байнгын хорооны групп дээр тавьж, бид нар бол Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээ бол шинэ мэдээллээр үргэлж хангаж байгаа. Та бол одоо эндээс хараад ашиглаж байгаа тийм ээ.

Тэгэхээр зарим гишүүддээ бид нар энэ статистикийнхаа мэдээллүүдийг дахиад гүнзгийрүүлээд яг өнөөдрийн бодлого гаргаад энэ өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэглэхэд нь шаардлагатай тэр бүтээгдэхүүнүүдийг нь бас цааш нь гүнзгийрүүлж гаргаарай гэж байгаа байхгүй юу. Ер нь бол одоо цаашидаа бид нар, бид нар энэ юуг хийх байх. Ер нь цаашидаа одоо дараагийн ингээд л Их Хурал 126 гишүүнтэй, гишүүдийн тоо нэмэгдэнэ. Байнгын хороон дээр их олон Их Хурлын бас бодлогын асуудлууд бас их явагдана. Байнгын хорооны ажил ачаалал нэмэгдэх ийм хандлагатай юм шиг байна лээ одоо энэ Их Хурлын хууль, Дэгийн тухай хууль харж байхад. Тэгэхээр Байнгын хорооныхоо гишүүдийг бол эдийн, юуны Үндэсний статистикийн хорооныхон бол ийм хэрэгтэй, ерөнхий одоо юу гэдэг юм гаргах ёстой, хуулийн дагуу гаргах ёстой статистик мэдээллээс гадна бодлого гаргахад шаардлагатай тэр мэдээллүүдийг датаг бид нарт боловсруулж мэдээгээр биш бүүр одоо дата боловсруулж, бодлого гаргахад хэрэглэгдэх энэ шаардлага хангасан ийм датаг бид нарт гаргаж өгч байгаарай л гэж хэлээд байгаа юм байна шүү. Энийг бодолцох, та бүхний цаашидаа ажилдаа тусгах ажил шүү.

Ингээд өнөөдөр гишүүд тайлан танилцуулгатай холбоотой, тайлантай холбоотой асуулт, санал хэлж ингээд дууслаа. Ингээд өнөөдрийн хуралдаанаар

Үндэсний статистикийн хорооны 2023 оны ажлын тайланг хэлэлцэж дууслаа. Ингээд та бүхэнд баярлалаа.

16.14 цаг

Тав. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүй

Дараагийн асуудал байгаа. Та, ажлын, дараагийн хэлэлцэх асуудал руу оръё. Танилцуулга хийх нөхдүүдийг оруулж байгаарай. Байнгын хорооны санаачилгаар хийж байгаа Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүйн талаарх мэдээлэл сонсъё гэсэн энэ мэдээллийг өнөөдрийн хэлэлцэх асуудлуудын, асуудлуудад оруулсан. Хамгийн сүүлийн асуудал байна. Ингээд танилцуулга хийх, танилцуулга хэн хийх юм бэ? Намхайдагва доктор та голд суучих, тэр 1 номер дээр суучих наад микрофон дээр. 1 номер дээр, 2 номер дээр зохицуулагч хэн билээ, Нинжин суучхаарай. Ингээд танилцуулгаа хийж байх. Би ажлын хэсгийг нь танилцуулчихъя. Үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн аргачлалыг Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд бүрэн нэвтрүүлэх арга зүй, ажлын хэсгийн хэсгийн гишүүн Доржготовын Намхайдагва НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх, Болорцоогийн Нинжин НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн менежер. Танилцуулгаа хийе, 1 номерын микрофоныг нэе. Намхайдагва доктор танилцуулгаа эхэлнэ үү.

Д.Намхайдагва: Сайн байцаана уу, та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн танилцуулгаар болохоор Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл гэх мэтчилэн төрийн удирдлагын үйл явцад үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг нэвтрүүлэх, хөгжлийн бодлого төлөвлөлтөд тулгамдаж байгаа

асуудлууд, тэгээд Улсын Их Хурал, Байнгын хороогоор хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийг хэлэлцэх явцад анхаарах асуудлууд дээр товч танилцуулга бэлтгэх шаардлагатай байна гэдэг үүднээс болбол энэ танилцуулгыг хийж байгаа.

Тэгэхээр та бүхэн маань сайн мэдэж байгаа. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсын хөгжлийн бодлогыг урт, дунд, богино хугацаанд хооронд нь уялдаатай, нэгдмэл цогц байдлаар төлөвлөхөөр болбол хуульчлагдсан. Гэвч бодлогыг хуулийг хэрэгжүүлэх явцад хөгжлийн бодлого төлөвлөлтийг нэвтрүүлж, бодлогын баримт бичгүүдийг батлах явцад тулгамдаж байгаа тодорхой асуудлууд болбол бас цөөнгүй байгаа. Бүрэн шийдэгдэхгүй байгаа асуудлууд болбол нэлээдгүй байгаад байгаа. Жишээлбэл бид нар энэ хөгжлийн бодлого төлөвлөлт маань үр дүн гэхээсээ үйл ажиллагааг санхүүжүүлдэг, төрийн байгууллагын хэрэгжүүлж байгаа бодлого төлөвлөлтөө болбол гарт нь гарц, үйл ажиллагаагаар хүрээгээ хязгаарлаж хардаг. Хоорондын уялдаа хамаарлыг нь уялдуулж төлөвлөх асуудал дээр, тэгээд улсын төлөвлөлт, орон нутгийн төлөвлөлтүүд бас хоорондоо бүрэн уялдаж чадахгүй. Асуудал үр дагавартай тэмцэх хандлагатай, асуудлын шалтгаан дээр төвлөрч бодлого төлөвлөлтүүд маань хийгдэж чадаа чаддаггүй.

Батлагдсан бодлогын баримт бичгүүдэд болбол бас үр дүн тодорхойлж байгаа боловч үр дүнгээ хэмжих шалгуур үзүүлэлтүүдээ бас бүрэн тодорхойлж батлагддаггүй. Тэгээд шалгуур үзүүлэлт тодорхойгүй учраас цаашидын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд асуудал үүсдэг гэх мэтчилнээр болбол хөгжлийн бодлогын, бодлого төлөвлөлтийн бодит хэрэгжилт дээр болбол анхаарах асуудлууд болбол бас цөөнгүй байгаа. Тэгээд энэ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн сайд маань

болбол холбогдох хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг болбол боловсруулах аргачлалуудыг батлаад урт, дунд хугацааны буюу 10 жилийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах аргачлал, мөн жилийн төлөвлөлтийн баримт бичиг буюу улсын болон аймаг, нийслэл хотын жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг болбол холбогдох журам, аргачлалуудыг болбол баталсан байдаг. Тэгээд энэ хүрээнд болбол 24 оны энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төлөвлөгөө болон орон нутгуудад аймаг, нийслэлийн 24 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг болбол энэ арга зүйнхээ хүрээнд болбол боловсруулах ажил болбол 24 онд хийгдсэн.

Одоо энэ батлагдсан аргачлалын хүрээнд болбол 25 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө маань болбол удахгүй Байнгын хороодоор, цаашилаад Их Хурлаар болбол хэлэлцэгдэх энэ шатандаа болбол явж байгаа. Тэгэхээр энэ хүрээнд болбол гол Улсын Их Хурал болон Байнгын хороод дээр энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийг нэг хэлэлцэх явцадаа гол анхаарах асуудлууд юу байна вэ энэ дээр товч мэдээлэл өгөөч гээд энэ удаагийн танилцуулга маань болбол хийгдэж байгаа.

Тэгэхээр хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад болбол гол анхаарах асуудлуудыг болбол бид товч байдлаар болбол нэгтгэсэн байгаа. Энэ дээр болбол 1 дүгээрт нь болбол үр дүнг нэгдмэл цогц, харилцан уялдаатай төлөвлөх хүрээнд Байнгын хороо болон Улсын Их Хурал дээр болбол хэлэлцэх явцад болбол анхаарах асуудлууд юу байж болох вэ гэдгүүдийг болбол энэ 1-ээс 10 гэсэн дарааллаар болбол гаргаж өгсөн байгаа.

2 дугаар багц асуудал маань болбол үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлоход болбол Их Хурлаар хэлэлцэх явцад гол анхаарах асуудлууд

маань юу байж болох вэ гэдгүүдийг болбол нэгтгэж болбол нийтдээ 6 үндсэн чиглэлээр болбол анхаарах асуудлууд дээр нь болбол нэгтгэл хийсэн байгаа. Тэгээд үр дүнг нэгдмэл цогц, харилцан уялдаатай төлөвлөх хүрээнд болбол Их Хурлаар хэлэлцэх болон Байнгын хороогоор хэлэлцэх явцад тухайн жилийн тэргүүлэх чиглэлийг ямар үндэслэл дээр тулгуурлаж гаргаж ирсэн бэ, мөн үр дүнгүүдийг үндэсний болон салбарын түвшинд хүлээгдэж үр байгаа үр дүн буюу урт хугацааныхаа бодлоготой хэрхэн уялдаж байгаа вэ, мөн огт үр дүн тодорхойлогдоогүй төсвийн ерөнхийлөн захирагчид мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүжилт аваад байгаа хөтөлбөр байна уу гэдэг талаас нь, мөн төлөвлөгөөнд төрийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нийлүүлэх үндсэн гарц, үр дүнгүүдийг болбол бүрэн төлөвлөж чадсан уу гэх мэтчилэн асуудлуудыг болбол энэ боловсруулсан төсөл дээр болбол анхаарч харах шаардлагатай байна гэдэг асуудлуудыг болбол нэгтгэсэн байгаа.

Үр дүн, хэмжих шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлох хүрээнд болбол бас анхаарах асуудал маань энэ үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт нь яг тэр үр дүнгээ хэмжиж чадаж байна уу, зорилтот түвшинээ хэр бодитой, зөв тодорхойлж чадсан байна вэ? Энэ шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдал хангагдаагүй асуудлуудыг цаашид яах вэ, ямар авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулагдсан уу гэдэг зүйлүүд дээр болбол анхаарал хандуулж, төсөл дээр Засгаас болон бусад субъектүүдээс боловсруулж оруулж ирж байгаа төсөл дээр энэ чиглэлээр гол нь анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна. Өмнөх хугацаанд болбол бид нар үндсэн төсөл арга хэмжээндээ илүүтэй төвлөрөөд үр дүнгээ баримжаалж хэлэлцүүлгүүдийг болбол хийж чадахгүй байна гэдэг асуудлыг болбол тавиад энэ хүрээнд танилцуулга бэлтгэх шаардлагатай байсан учраас гол, гол асуудлуудыг ийм

байдлаар нэгтгэсэн байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Баярлалаа. Намхайдагва доктор танилцуулга хийсэнд. Өнөөдөр энэ Байнгын хороон дээр 5 дахь асуудал болж хамгийн сүүлийн асуудал болж орж ирж байна. Дээрээс нь гишүүд ачаалал ихтэй ажиллаж байгаа. Гэхдээ ямар ч байсан бид нар Байнгын хороон дээр танилцуулга хийгээд, энэ жилийн төлөвлөгөөний өмнө нэг танилцуулга хийчих ёстой. Бид нар энэ материалаа гишүүддээ тарааж өгч, дахиж дараагийн гишүүддээ аль болохоор мэдээллээр хангана I-д.

2-т хамгийн гол нь ингэхээр Баттөмөр гишүүнээ, энэ жил энэ хавар энэ чуулганаар бид нар энэ Их Хурлын тогтоол гаргая гээд байгаа юм. Ер нь бол энэ аргачлалаар энэ төлөвлөгөөгөө, жилийнхээ төлөвлөгөөг хийж орж ирж байя, дунд, урт хугацааныхаа төлөвлөгөөг уялдуулж хийж орж ирж байя. Тэгвэл энд Байнгын хороон дээр бид нар төлөвлөгөөгөө авч хэлэлцэх, тэгээд жилийн дараа ажлынх нь төлөвлөгөөнийх нь гүйцэтгэлийг дүгнэж, тайланг нь сонсохдоо энд бид нар энэ жилийн өмнө төлөвлөсөн төлөвлөгөөг нь барьж байгаад энэ нэгдсэн энэ аргачлалыг хэрэгжүүлээд эхэлчихвэл бид нарт бас амар хялбар болох нь. Энэ хэлэлцүүлэг үр дүнтэй болох нь гэдэг агуулгаар энэ хэлэлцүүлгийг энэ танилцуулгыг өнөөдөр хийж байгаа юм. Ингээд Баттөмөр гишүүн та асуулт танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байвал нэрсээ хэлнэ үү. Асуулт асууя гээд. Баттөмөр гишүүн, Баттөмөр гишүүнээр тасаллаа. Тэгээд Баттөмөр гишүүн асуултаа асууя. Та битгий дараарай, наадах дээрээ.

Б.Баттөмөр: Европын холбооны санхүүжилттэй энэ төсөл явж байгаа юм байна л даа. Тэгэхээр энэ яах вэ дээ гаднын орнууд ингээд санхүүжүүлээд явдаг. Энэ хөгжлийн төлөвлөлттэй холбоотой л асуудал л даа. Бид нар чинь

болбол ингээд л либерал загвараар Америкт ингэдэг, Европын холбооны улсад ингэдэг, бид ингэж хөгжих ёстой гээд л ингээд л. Монгол загвар гэж байх ёстой гэж би ойлгодог юм л даа. Монгол чинь бол Америк биш, Монгол бол Европын холбооны улсууд биш, Монголын хөгжил, газар зүй, байришил, онцлог, цаг агаар, хүмүүсийн ухамсар, мэдлэгийн түвшин гээд их олон асуудал байгаа шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ эдийн засаг ингээд л өсөөд 7 хувийн өсөлттэй л гэж байгаа байхгүй юу. Тэгтэл хүртээмж алга, өгөөж алга, ард иргэдэд. Тэгэхээр та нар одоо юу гэж тооцож байгаа вэ, өнөөдрийн энэ яваад байгаа энэ ер нь бид нарын энэ асуудал ер нь юу болж төгсөж байна вэ? Хүртээмж алга байна, ядуурал 27 хувьтай, 15 хувь дахин ядуурах магадлалтай. Баян, хоосны ялгаа бол өдөр тутам нэмэгдэж байгаа. Өрхийн орлого болбол яг инфляцтай нь уялдуулаад яахаар тооцохоор бол өрхийн орлого нэмэгддэггүй байгаа.

Уг нь үр ашгийг л санхүүжүүлж байх ёстой л талд нь байгаа юм л даа. Тэгээд одоо бид нар дандаа нэг ийм жагсаачхаад л тэрийгээ санхүүжүүлээд яваад байдаг. Би энийг яагаад хэлж байна гэхээр зэрэг 2024 онд энэ үйл ажиллагааны 24 оны хөгжлийн бодлогыг төлөвлөгөөг би ахалсан юм. Нэлээн их олон асуудлууд орж, тэгээд төсөвт орж ирэхдээ байхгүй, 32 асуудал байхгүй ийм л байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг бид энэ юу төлөвлөд, юу яваад байна вэ гээд ингээд асуудал гарч ирж байна. Төрийн үүрэг болбол юу гэхээр зэрэг асуудлыг дандаа урьдаас харах ёстой юм. Бид нар дандаа хойноос нь байж байна шүү дээ. Нөгөө хагархай цонхны онол. Дандаа ингээд Монголчууд чинь тэрийг чинь нөгөө ниргэсэн хойно нь хаширав гэж хэлдэг шүү дээ. Асуудлыг урьдаас харж чадахгүй, төлөвлөж чадахгүй, дандаа хойноос нь хөөцөлдөж байна шүү дээ. Тэгээд энэ асуудлуудыг та нар юу гэж бодож байна, ямар юм байна гээд I дүгээрт.

2 дугаарт болбол Монголчууд бол ер нь Монгол Улс яаж хөгжих вэ гэхээр Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, Монгол Улсын хөгжлийн загвар нь өөрөө их зөв байх ёстой. Иргэд нь болбол баялаг бүтээх ёстой. Нөгөө г... гэж одоо нөгөө эрээнд хайх гэж тийм ээ. Одоо ингээд 30 жилийн хугацаанд чинь бид нар үндсэндээ тэр социализмын үед бий болгосныгоо хувьчлаад авчихлаа. Бүх газрыг болбол аваад наймааны хэрэгсэл болчихсон. Ашигт малтмалын лиценз худалдаж байна. Тэгээд аар саархан зүйл хийгээд, баялаг бүтээхгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ энэ асуудлыг энэ төсөл дээр та нар ер нь юу гэж харж байгаа вэ? Тэгээд энэ чинь тийм амар хялбар л амьдраад байна шүү дээ. Баялаг бүтээдэг ард түмэн хөгждөг. Жишээ олон байна шүү дээ тийм ээ. Тэгэхээр миний асуух гэж байгаа асуудал бол Монгол Улсын өнөөдрийн яг хөгжлийн бодлого, загвар, хөгжлийн төлөвлөлт ер нь та нар одоо энэ гаднын тусламжтайгаар төсөл хэрэгжүүлж байна, юу гэж бодож байгаа юм бэ? Би болбол одоо юу гэхээр зэрэг хөгжлийн Монгол загвар байх ёстой. Хөгжлийн Сингапур загвар гэж байгаад бид хөгжчихсөн юм гэж тэр Сингапурын Ерөнхий сайдын хэлсэн үг байгаа шүү дээ. Тэр Монгол загварыг та нар юу гэж харж байна вэ? Би бол баялаг дээрээ суурилсан хөгжлийн бодлого байх ёстой гэж ингэж хардаг. Тэгэхээр энэ төслийн эцсийн үр дүнг.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Ер нь тийм. Баттөмөр гишүүн та бүгдээс асууж байгаа гол санаа бол та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Та бүхэн ингээд энэ хэдэн жил ажиллаж байгаа билээ энэ юу чинь. Ер нь зүгээр яах вэ шууд хариулчих юугүй. Төсөл эхлээд 3 дахь жилдээ ажиллаж байгаа. Тийм. Тэгэхээр ингээд бид нар энэ хөгжлийн бодлого төлөвлөлт гээд энэ хөгжлийн том утгаар нь харж байгаа учраас энэ нь ямар загвар босож ирэх бололцоотой байна гэж харж байгаа гэдэг дээр анхаарал та бүхэн саналаа сайн хэлнэ үү гэж байгаа шүү. Тэгээд сайхан цаг хугацаа болж өгвөл бид нар

бас гайгүй бас энэ дээр цаг хугацаагаа зөв ашиглаад хангалттай хугацаа өгье гэж бодож байна. Тэгээд хариулаадах. Ажлын хэсгийн 1 номерыг нь нээж өгье.

Д.Намхайдагва: Баярлалаа, асуултад хариулъя. Тэгэхээр одоо бид хэдийн хувьд энэ төслийн зүгээс тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам бусад оролцогч талуудтай хамтарч ажиллаж байгаа энэ нэг гол ажлын хүрээнд болбол яг тэр Монголын онцлогт тохирсон загвар юу байх юм бэ гэдгээ гаргахаас их илүүтэйгээр эхлээд ерөнхийдөө энэ үр дүнг буюу бид нарын нөгөө нэг нийгэмд тулгамдаад байгаа тэр ажилгүйдэл, ядуурал, түгжрэл гээд энэ гол, гол асуудлуудыг их богино хугацаанд оновчтой шийдэхийн тулд ямар нийтлэг арга зүй байна вэ гэдэг хүрээнд болбол үндсэн аргачлал, загваруудыг нь болбол нэвтрүүлэх ажил болбол хийгдээд явж байгаа энэ 3 жилийн хугацаанд. Энэ маань болбол ерөөсөө нэг улсын ч гэдэг юм уу онцлогт тохирсон тийм загвар бол биш. Ер нь нийтлэг бид нар үр дүн гаргахын тулд ер нь яаж ажиллах ёстой юм бэ, яаж ийм хязгаарлагдмал санхүүжилт, нөөцөөр илүү үр дүнг яаж илүү сайн гаргах юм бэ, хүсэн хүлээгээд байгаа тэр урт хугацааныхаа үр дүн дээр хүрэхдээ ямар арга зүйгээр явбал боломжтой юм бэ гэдгийг улс орнууд туршаад нийтдээ нийтлэг байдлаар гол юмнуудаа харчихсан энэ арга зүйн асуудлыг болбол Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний арга аргачлалууд дээр болбол нэвтрүүлэх ажлыг болбол хийгдээд, ингээд 3 дахь жилийнхээ нүүрийг үзээд явж байна.

Тэгэхээр энэ дээр болбол гол зарчим нь болбол юу байна вэ гэхээр бид нар бүх асуудлыг болбол төр шийдэхгүй. Энэ нийгэмд тулгамдаад байгаа гол, гол асуудлуудыг хооронд нь уялдуулж харж байгаад, хамгийн чухал асуудлыг шийдсэний үндсэн дээр тэрний нөлөөгөөр бусад асуудлууд болбол заавал ч үгүй төрийн оролцоогүйгээр шийдэгдэх боломжууд байна. Тийм учраас энэ асуудлуудыг, үр дүнгүүдийг хооронд нь их

сайн уялдуулж төлөвлөх ёстой юм гэдэг зүйлийг энэ үр дүнд суурилсан удирдлагын хүрээнд болбол хөндөж байгаа.

2 дугаарт нь болбол ямар асуудал хөндөж байна вэ гэхээр бид нар агаарын бохирдол, ажилгүйдэл гэх мэтчилэн нийгэмд тулгамдаж байгаа ерөнхий асуудал, асуудлаас үүсэж байгаа үр дагаврыг хараад байна. Асуудлыг цааш нь нарийвчлаад шалтгаануудыг нь олж илрүүлээд, тэр шалтгааныг нь болбол шийдэх юм болбол тэр асуудал шийдэгдэхээр байна. Тэгэхгүй л болбол түгжрэл их байна гээд зам бариад л байх юм болбол үндсэн хэрэгцээ нь байж байгаа учраас асуудал маань болбол бүрэн шийдэгдэхгүй. Тэгэхээр иргэдийгээ зөв дадал хэвшилтэй болгохын тулд заавал ч үгүй иргэд болбол хувийнхаа автомашинаар хөдөлгөөнд оролцдог биш, нөгөө бусад нөөц боломжуудыг нь эсвэл нийтийн, жишээлбэл нийтийн тээврийг нь оновчтой болгоод өгөх юм болбол хүн болгон өглөө гэрээсээ машинаа аваад гарах шаардлага байхгүй. Тэгэхээр тийм асуудлыг үүсгээд байгаа үндсэн шалтгаануудыг олж, түүн дээр төвлөрч шийдвэр гардаг, бодлого тодорхойлогддог, төсөл үйл ажиллагаанууд тийшээ чиглэдэг байх ёстой гэдэг асуудлыг хөндөж байгаа.

Бас нэг 3 дугаар асуудал нь болбол нэгэнт бодлого төлөвлөлтийн хүрээнд бид нар тодорхой асуудал хөндөөд үр дүн тодорхойлсон болбол тэр үр дүнгүүдээ шат шатдаа хэмжээд, тэр үр дүн рүүгээ бүх оролцогч талууд нэгдмэл зорилготойгоор хамтдаа тэмүүлж байх ёстой юм байна гэдэг ийм гол, гол асуудлуудыг болбол энэ аргачлалууд дээр болбол хөндөж байгаа юм. Тэгэхээр энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийнхөө үндсэн хууль, журам, аргачлалууд дээрээ үүнийгээ нэг мөр шингээгээд, тэгээд цаашдаа төлөвлөлтүүдээ гаргаж ирэхдээ Монголын онцлог юу вэ гэдэг дээрээ нөхцөл байдлаа оновчтой тооцоод, Монгол загвараа гаргаад ирэх боломжтой юм гэж харж байгаа.

Тэгэхээр цаашид болбол эхний ээлжид болбол энэ аргачлалуудаа оролцогч талууд нэг мөр ойлгоод, зөвхөн тодорхой үйл ажиллагаанууд дээр биш, байгаа нөөц боломжоо бүх асуудлыг шийдэхэд зарцуулах биш, хамгийн гол асуудал дээрээ илүү хүн хүч, илүү цаг хугацаа, хөрөнгө санхүүг шийддэг энэ үндсэн сууриа бүрдүүлчихсэнийхээ дараагаар яг Монгол загвар нь юу байх юм бэ гээд гаргаад ирэх юм болбол боломжтой гэж. Тэгэхээр Монголын онцлогт тохирсон загвар юу байх байх вэ гэдгийг болбол манай энэ төслийн хүрээнд болбол хөндөөгүй байгаа юм. Тийм. Тэгэхээр болбол үндсэн суурь арга зүйн үр дүнг хангахын тулд үр дүнд суурилсан удирдлагыг нэвтрүүлэх хүрээнд юу байж болох вэ гэдэг асуудлыг хөндсөн. Энэ 3 жилийн хугацаанд болбол энэ төслийн хүрээнд болбол оролцогч талуудтай нэлээн хамтарч ажилласан байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн нэмэлт асуулт асууя.

Б.Баттөмөр: Тэгээд л их сайхан, сайхан нэртэй төсөл энэ 30 хэдэн, 32, 3 жилийн хугацаанд зөндөө л хэрэгжлээ. Та нар болбол одоо нэг яг гол асуудал руугаа орохгүй. Би хэрвээ шийдвэр гаргадаг байсан бол Европын холбоотой энийг Монгол хөгжлийн загварыг тодорхойлох ямар байх юм гэдгийг л ингэх хэрэгтэй. Тэгтэл нэг тойруулаад тэгээд л ямар юмны хамтарч шийдье гээд л ингээд л төр оролцоогүй байх ч, төрийн оролцоотой оролцоогүй аль аль нь байна. Төрийн оновчтой зохицуулалтууд хэрэгтэй. Төрийн зохицуулалтгүй улс гэж дэлхийд хаана ч байхгүй. Америк тив, Европын холбоо бүгд зохицуулалттай байж байгаа. Тэр нөгөө үл үзэгдэгч гар гэдэг чинь аль хэдийн моодноос гарчихсан шүү дээ. Дэлхийд өнөөдөр аль болохыг урьдчилаад урьдчилж харж, зөв төлөвлөж, зөв зохицуулж байж улс эх орон нь хөгжиж байгаа шүү дээ. Тийм учраас болбол энэ төслийн юун дээр та нар маань одоо жоохон үр ашиг муутай л ер нь төгсөх байх даа. Энэний үр дүн.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн тодруулж гүйцээж, асуултаа гүйцээж асууя, 3 минут тавьчих даа.

Б.Баттөмөр: Энэ дэлхий чинь болбол хөгжлийн их олон загвар байна шүү дээ тийм ээ, хурдтай, хуримтлалтай хөгжлийн загвар, социал демократ загвар, тэр зүүний чиглэл баримтлалтай төрийн их өндөр оролцоотой тэр нордик загвар гээд их олон загварууд байж байгаа юм. Булангийн орнуудын тэр баялагт суурилсан загвар гээд. Тэгээд энэ загварыг л их зөв гаргах ёстой юм байгаа юм. Түүнээс биш өнөөдөр төр юу ч харахгүй байж байгаад 1,2 сая машинтай Монгол болоод, 850 мянга нь Улаанбаатарт явж байгааг бол судлаад байх юм байхгүй шүү дээ. Тухайн үеийн удирдлагууд, тухайн үеийн төр барьж байсан улсууд өнөөдрийг хүртэл энэ машиныхаа зохицуулалтуудыг хийгээгүй, дээрээс нь зам харилцаагаа өргөжүүлээгүй. Утаа гээд л тэгтэл хөдөө орон нутгийн ядуурсан улсууд Улаанбаатарт орж ирээд, хүн амын бараг 60-аад хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна шүү дээ. Тэгэхээр чинь бодлогогүй, зохицуулалтгүй л явж байгаа байхгүй юу. Энийг судлаад ингээд нэг их айхтар мөнгө зараад байх шаардлага байхгүй шүү дээ.

Тийм учраас та бүгдийг бол хугацаа үлдсэн байдаг юм бол ийм загвар дээрээ үзээч гэж байгаа юм. Ядуурал буурахгүй байна. Би түрүүн хэллээ тийм ээ. Өрхийн орлого буурах юу өсөхгүй байна. Хөгжлийн бодлого төлөвлөлт төсөвтэйгөө уялдахгүй байна. Тийм учраас болбол би болбол энэ одоо судалсан судалгаа дээрээ үндэслээд та нар энэ хөгжлийн тодорхой загвар бодлогыг л их тодорхой гаргаж ирэх ёстой. Энэ чинь 3-хан сая хүнтэй. Менделеевийн үелэх систем тэр чигээрээ байна. 2 хөрш бидэнд тусалж байна. 3 дахь хөрш одоо бидэнд тусалж байна. Яагаад Монгол хөгжихгүй байгаа юм бэ? Тэгэхээр зэрэг Монгол хүнээсээ болж

байгаа байхгүй юу. Монгол хүнийг хөгжүүлэх асуудал бол 1 номерын асуудал. 2 дахь нь баялаг дээрээ менежмент хийх асуудал. 3 дахь нь тэр хөгжлийн их оновчтой бодлого төлөвлөлтүүдийг хийх асуудал, үр ашгаа дээшлүүлэх асуудал. Хүн бүр хөдөлмөр хийж амьдарна гэдэг тэр ухамсрыг хүнд төлөвшүүлэх асуудал. Тэгээд ёс зүй, ёс суртахууны асуудал.

Манайхан ёс зүй, ёс суртахуун гэхээр ерөөсөө 30 жил хэрэглээгүй. Хамгийн хөгжлийн суурь чинь ёс суртахуун гэдэг юм байна шүү дээ. Сүүлийн үед хүмүүс энийг их ойлгодог болж байна. Худалдааны танхим дээр Бизнесийн ёс зүйн төв гэж байгууллаа шүү дээ. Тэгээд ийм юм руу орж яахгүй бол та нар тэгээд л нэг тойруулаад л иймэрхүү төсөл болбол Монгол Улсын хөгжилд болбол үр дүн муутай л даа. Европын холбоо энийг санхүүжүүлэе, ингээд санал санаачилгаар яг гол юм руугаа орж л ингэж л ажиллахгүй бол тэгээд нэг хэсэгхэн ингэж явж байгаад л нэг зөвлөмж гаргаад л ингээд л төгсчихдөг л юм болчих вий дээ. Энэ бол үнэхээр тулгамдсан асуудал шүү.

21 дүгээр зуунд болбол энэ 28 хувийн ядууралтай ийм улс цаашаагаа хөгжих ийм бид хөгжиж байна гэж үзэх юм уу, юу гэж үзэх юм бэ? Та нар минь зөв гаргаж өгөөч. Хөгжилд чинь одоо юу саад болж байна, бид өөрсдөө саад болж байна шүү дээ. Чаддаг, чаддаггүй хүмүүс төрийн ажил хийж байна. Монгол хөгжихгүй байгаагийн энэ өнөөдрийн шалтгаануудыг та нар энэ хөгжлийн бодлого төлөвлөлт гэж ингэж байгаа юм чинь тэрийг гаргаж тавих ёстой шүү дээ. Хүнээ бэлдэх ёстой. Төрийн ажлыг төрд бэлтгэгдсэн хүн, мэдлэгтэй хүн хийдэг болохоос биш төрийн ажлыг удирдах ажлыг очиж сурч хийдэг байхгүй юу. Маши их олон учир шалтгаанууд байгаа байхгүй юу нөхдүүд. Тэгээд энэ болгоныгоо бодож, зөв энэ төслийг болбол бас гаднаас өгч байгаа учраас үр дүнтэй төгсгөх ёстой шүү. Түүнээс биш нэг хэдэн цаас яагаад л нэг

тийм хамтаараа тэгнэ, ингэнэ, ингэнэ, та нарын үг бол мэдэхгүй.../минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Та болчихсон уу? Энэ дээр санаа бодлоо бас солилцоорой Намхайдагва доктор. Ер нь саяын одоо Баттөмөр гишүүний хэлж байгаа бол цаашдаа дахиад ийм төсөл, энэ төсөл бол энүүгээрээ ингээд дууссаны дараа бол дахиад энэ дараагийн түвшинд оруулсан төслүүд орж ирүүлж, одоо ийм ажлуудыг хийвэл зүгээр байна шүү гэдэг хамгийн гол санал бодлоо сая илэрхийллээ. Ингээд өнөөдөр та бүхний энэ өгсөн материалуудыг бол бид нар өнөөдөр ингээд Байнгын хороон дээрээ бид нар энэ та бүгдийн, та бүгдээс мэдээлэл сонссон учраас гишүүддээ би энэ цаасаар материалаар өгнө. Тэгээд гишүүд дээрээ энэ дээр бас та бүхэнтэй гүнзгийрүүлж уулзалт хийхээр бол хувиараа ч юм уу, гишүүд энэ тусдаа холбогдож нэмэлт асуултууд, нэмэлт мэдээлэл хэрэгтэй болбол гишүүд өөрсдөө хандах байх. Тэгээд ингээд өнөөдөр энэ, ингээд өнөөдөр яаж байгаа билээ, дуусаж байгаа биз дээ энүүгээрээ. Энэ сүүлийн асуудал байгаа болж байгаа. Ингээд би бас жоохон дараагийн ажил руу орох ийм шахуу хугацаатай байгаа учраас энэ Баттөмөр гишүүнтэй, та өрөөндөө ороод манай бас энэ дараагийн үргэлжлүүлээд энэ төслийнхөнтэй бас нэмэлт асуулт байвал асууж болно шүү, цаг хугацааны хувьд. Дуусаагүй байгаа. Энэ явж байгаа.

Хамгийн гол нь байна шүү дээ Баттөмөр даргаа, энэ цаашдаа үргэлжлүүлж явж бид нар таслахгүй явуулах ёстой л байх гэж, хэрэгтэй гээд үзээд байгаа байхгүй юу. Энэ дундаас нь бид нар ингээд нэг Их Хурал, нэг Засгийн газрын нэг ийм бүрэн эрх дууслаа гээд энэ төсөл зогсож болохгүй, цаашаа үргэлжлүүлээд энэ зорилгодоо хүрч, энэ төсөл гүйцэд ажиллах ёстой шүү. Энэ төслөөсөө гаргаж байгаа тэр аргачлал, зөвлөгөөг бүрэн энэ Засгийн газар авч хэрэгжүүлэх ёстой шүү гэдэг дээр Их Хурлаас тогтоолын төсөл бол гаргаж,

чиглэл өгөх гээд байгаа юм. Тийм учраас бид нар гишүүддээ эхэлж сайн ойлголтуудыг нь өгөөд, ямар энэ төсөл хэрэгжсэнээр бид нарт ямар бүтээмж, ажлын бүтээмж бид нарын, ялангуяа Их Хурлын өөрийн бодлого гаргаад, бодлогоо хэрэгжүүлж байгааг хянаад ингээд энэ ажил хэргээ явуулахад үр дүнтэй болох юм гэдэг дээр бид нар бас гишүүддээ ойлголт өгч байж, энийг цааш нь Засгийн газартаа чиглэл өгөөд, цааш нь Засгийн газарт дараа дараагийн Их Хурал шаардаж ажиллаж, энийг ажил хэрэг болох ёстой гэдэг үүднээс бид нар хатуу бодлоготой, энэ бодлого тасрахгүй явах энэ талд нь л бид нар бодлого гаргая гэдэг үүднээс энэ танилцуулгыг хийж байгаа юм.

Тэгээд уул нь өнөөдөр гишүүд энэ олон хурлууд давхацчихсан байгаа учраас ингээд зарим гишүүд маань оролцож чадаагүйд бас та бүхэн ойлгож байгаа байх. Ингээд танилцуулга хийсэн төслийн төсөл хэрэгжүүлж байгаа зөвлөхдөө, төслийн менежертээ баярлалаа.

16.42 цаг

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа. Баярлалаа ингээд бүхэнд. Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 4 сарын 17-ны хурал үүгээр өндөрлөлөө.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

